



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200

Утас/Факс: (976-11) 32 14 33

Цахим шуудан: international@nso.mn

Цахим хуудас: www.nso.mn

2023.03.30 № 01/261

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Ц.ЦЭРЭНПУНЦАГ ТАНАА

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу тус хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг системчилсэн үнэлгээний хамт хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт <sup>25</sup> хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Б.БАТДАВАА

142623600320



**ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2022**

Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	iii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	v
ӨМНӨХ ҮГ .....	vi
2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ .....	9
НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	10
1.1. АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ .....	11
1.2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТООЛЛОГО, СУДАЛГАА .....	12
1.2.1 Статистикийн мэдээ .....	12
1.2.2 Тооллого, судалгаа .....	13
1.3. ТООЦОО, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ .....	28
1.3.1 Суурь тооцоо .....	29
1.3.2 Судалгаа шинжилгээ .....	30
1.4. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ ЭХ ҮҮСВЭР .....	40
1.5. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ .....	42
1.5.1 Хэвлэмэл бүтээгдэхүүн .....	42
1.5.2 Цахим бүтээгдэхүүн .....	42
1.5.3 Сургалт, мэдээллийн үйлчилгээ .....	43
ХОЁР. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	43
2.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	46
2.2. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ШИНЭЧЛЭЛ .....	46
2.2.1 Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар /СҮАЕЗ/ .....	42
2.2.2 Мэдээллийн чанар .....	42
2.2.3 Статистикийн хууль эрх зүйн шинэчлэл .....	43
2.2.4 Цахим шилжилт .....	46
2.2.5 Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах "Төрийн их өгөгдөл" төсөл .....	48
2.3. ДОТООД АЖИЛ .....	51
2.3.1 Хүний нөөц .....	51
2.3.2 Дотоод ажлын цахимжилт .....	52
2.3.3 Санхүү, хөрөнгө оруулалт .....	52
2.4. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА .....	53
2.4.1 Олон талт хамтын ажиллагаа .....	54
2.4.2 Хоёр талт хамтын ажиллагаа .....	55
2.5. ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА .....	55
2.5.1 Дотоод аудитын үйл ажиллагаа .....	55
2.5.2 Эрсдэлийн удирдлага .....	56
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОМООХОН АЖЛУУД .....	57
ГУРАВ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ .....	61
ХАВСРАЛТ .....	78

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ, БЭРХИШЭЭЛ, хувиар .....	14
ЗУРАГ 2. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТ, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар.....	15
ЗУРАГ 3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, тооллого явагдсан оноор .....	16
ЗУРАГ 4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ТОО, төрлөөр 2021 он.....	16
ЗУРАГ 5. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАРХААЛТ, аймаг, нийслэлээр, 2021 он.....	17
ЗУРАГ 6. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, тооллого явагдсан оноор .....	18
ЗУРАГ 7. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТОО, төрөл, тооллого явагдсан оноор.....	18
ЗУРАГ 8. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр.....	20
ЗУРАГ 9. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр .....	20
ЗУРАГ 10. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, улирлаар, мянган хүн .....	22
ЗУРАГ 11. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар.....	22
ЗУРАГ 12. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар.....	23
ЗУРАГ 13. БҮРТГЭЛЭЭ ХИЙЛГЭДЭГГҮЙ ГОЛЛОХ ШАЛТГААН, хувиар, 2022 он.....	25
ЗУРАГ 14. СҮҮЛИЙН 5 ЖИЛД НИЙСЛЭЛЭЭС ОРОН НУТАГ РУУ ШИЛЖИН СУУРЬШИГЧ ӨРХҮҮД ДЭХ ХҮН АМЫН ТОО, нас, хүйсийн бүтцээр.....	26
ЗУРАГ 15. АМЬДРАЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ НИЙСЛЭЛД БАЙСАН ҮЕИЙНХЭЭС ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДСӨН ТАЛААРХ ШИЛЖИГЧДИЙН СЭТГЭГДЭЛ.....	27
ЗУРАГ 16. НИЙСЛЭЛЭЭС ОРОН НУТАГТ ШИЛЖИН СУУРЬШСАН 18+НАСНЫ ИРГЭДИЙН ХУВЬ, шилжилтийн талаарх сэтгэл ханамжийн түвшнээр, бүсээр, байршлаар .....	27
ЗУРАГ 17. ДНБ-ИЙ ХЭМЖЭЭ, их наяд төгрөгөөр .....	28
ЗУРАГ 18. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар /2015 оны зэрэгцүүлэх үнээр/ .....	28
ЗУРАГ 19. УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭГЭЭС 2000М-ИЙН РАДИУС ТОЙРОГТ ХАРЬАЛАГДАХ СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ ЕБС-ИЙН СУРАГЧДЫН ГЭР БОЛОН СУРГУУЛИЙН БАЙРШИЛ .....	34
ЗУРАГ 20. ГЭР-СУРГУУЛЬ МАРШРУТЫН ДАВХАРДАЛ АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНД ҮЗҮҮЛЖ БУЙ АЧААЛАЛ.....	35
ЗУРАГ 21. ЭЕШ-Д ХАМРАГДАГЧИД БОЛОН ЕБС ТӨГСӨГЧИД, тоо, харьцаа.....	36
ЗУРАГ 22. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЕ ДОТОРХ ҮНЭМЛЭХҮЙ ӨГСӨЛТ, 2010-2020 он, төрсөн байршлаар .....	37
ЗУРАГ 23. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, сараар, хувиар .....	39
ЗУРАГ 24. 7 ХОНОГИЙН МЭДЭЭНД ҮНДЭСЛЭСЭН ИНФЛЯЦЫН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО.....	40
ЗУРАГ 25. СҮҮНИЙ ҮНЭ, төгрөг, томоохон супермаркетаар, өдрөөр.....	40
ЗУРАГ 26. ҮСХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	45
ЗУРАГ 27. ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ .....	47
ЗУРАГ 28. ХҮНИЙ НӨӨЦ, байршил, хүйсээр .....	51
ЗУРАГ 29. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ, эдийн засгийн ангиллаар.....	53

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ам бүлийн тоо, мянган хүнээр.....	14
ХҮСНЭГТ 2. МАЛЫН ТОО, төрлөөр, сая толгой, жил бүрийн эцэст .....	15
ХҮСНЭГТ 3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, төрөл, тооллого явагдсан оноор .	17
ХҮСНЭГТ 4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр .....	17
ХҮСНЭГТ 5. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, бүс, аймаг, нийслэл, хүйсээр.....	18
ХҮСНЭГТ 6. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, улсын дунджаар .....	20
ХҮСНЭГТ 7. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, зарлагын төрөл, улсын дунджаар .....	21
ХҮСНЭГТ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2022 оны 12 дугаар сард .....	29
ХҮСНЭГТ 9. МОНГОЛ УЛСЫН ЯДУУРЛЫН ШИЛЖИЛТ, интервал үнэлгээ, загвар .....	30
ХҮСНЭГТ 10. АГААРЫН БОХИРДЛЫН ХӨДӨЛМӨРИЙН НИЙЛҮҮЛЭЛТЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, threshold регрессийн загвар .....	31
ХҮСНЭГТ 11. РЕГРЕССИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН .....	32
ХҮСНЭГТ 12. ТООЦООНЫ ҮР ДҮН, байршлаар .....	33
ХҮСНЭГТ 13. УРТ БА БОГИНО ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН .....	34
ХҮСНЭГТ 14. ЗАГВАРЫН ҮР ДҮН .....	38
ХҮСНЭГТ 15. ТӨРИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН ХӨГЖҮҮЛЭХ, УДИРДАХ ТӨСЛИЙН ЗАРДАЛ .....	49
ХҮСНЭГТ 16. ҮСХ-НЫ 2016-2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СЭДЭВ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА .....	61
ХҮСНЭГТ 17. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	61
ХҮСНЭГТ 18. 2022 ОНЫ ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ.....	71
ХҮСНЭГТ 19. 2020, 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ГАРСАН ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ.....	73
<b>СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ 1.</b>	
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1.1. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛСНААР ХЭМНЭСЭН ЦААС.....	76
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1.2. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛСНААР ХЭМНЭСЭН ЗАРДЛЫН ТООЦОО.....	76

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНБТ	Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого
АНДЭЗНК	Ази Номхон Далай Орнуудын Эдийн засаг, Нийгмийн Комисс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АХС	Ажиллах хүчний судалгаа
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОЭЗДС	Байгаль орчин, эдийн засгийн дансны систем
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГТСМТТ	Гааль, Татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв
ДБ	Дэлхийн Банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХүС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ПАРИС/PARIS21	XXI зууны Статистикийн төлөөх түншлэл/The Partnership in Statistics for Development in the 21 <sup>st</sup> Century
СҮАЕЗ	Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ХАА	Хөдөө аж ахуй
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХС	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
ШЕЗ	Шүүхийн өрөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
САPI	Computer Assisted Personal Interviewing
САTI	Computer Assisted Telephone Interviewing
IAEG-SDG	Inter-agency and Expert Group on SDG
SPS	Statistical Production System

## ӨМНӨХ ҮГ

Үндэсний Статистикийн Хороо нь хэрэглэгчдийн эрэлтэд тулгуурласан статистик мэдээллийг боловсруулж, нийтэд түгээх замаар Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилт тавин ажиллаж байна. Бид өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа энэхүү тайлангаар танд хүргэж байна.

Үндэсний Статистикийн Хороо нь 2022 онд улсын хэмжээнд 2 тооллого, 9 түүвэр судалгаа зохион байгууллаа. Тухайлбал, 10 жил тутамд явуулдаг Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгуулж, 297 мянган өрх, 2.9 мянган ААНБ-ыг хамрууллаа. Тооллогод өндөр нарийвчлалтай сансрын зургийн мэдээлэл ашиглаж тариалангийн талбайн байршил, өрх, ААНБ-ын байршлын цэгийг тэмдэглэснээрээ онцлог байлаа. Тооллогын дүнгээс харахад ХАА-н салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйлс 10 жилийн өмнөхөөс дорвитой өөрчлөлтгүй буюу хүндрэл бэрхшээлтэй хэвээр байгаа нь ажиглагдсан. Тухайлбал орон нутагт хүний нөөц хомс, байнгын болон түр ажиллагч олдохгүй байхаас гадна газар тариалангийн тоног төхөөрөмжийн шинэчлэл удаан буюу дундаж ашигласан жил 10.8 байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна. Мөн Мал, тэжээвэр амьтдын 2021 оны жилийн эцсийн тооллогыг зохион байгуулахад улсын хэмжээнд 71.1 сая толгой мал тоологдлоо.

2022 онд жил бүр тогтмол зохион байгуулдаг Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаанаас гадна Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа болон Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг анх удаа улсын хэмжээнд бие даасан хэлбэрээр зохион байгууллаа. Эдгээр тооллого, түүвэр судалгаа нь “Тогтвортой Хөгжлийн Зорилго”-ын үзүүлэлтүүдийг тооцох, төр болон хувийн хэвшлийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой мэдээлэл болсон гэж дүгнэж байна.

Бид өнгөрсөн онд статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын хэрэгжилтийн хүрээнд “Статистикийн чанарын удирдлагын хүрээ, хэм хэмжээ” баримт бичгийг шинэчлэн баталсан. Мөн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр онцгой анхаарч 5 багц журам болон статистикийн мэдээний уялдааг хангах үзүүлэлтийг баталж, мөрдөж эхэллээ. Ингэснээр статистикийн өгөгдөл, мэдээллийн чанарыг тухай бүрд үнэлэх, өгөгдөлд алдаа гарахаас урьдчилан сэргийлэх, арга зүйн нэгдмэл байдлыг сайжруулах, задгай өгөгдлийг уялдуулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоог бүрдүүлэх зорилт тавиад байгаа юм. Үүнээс гадна “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан баталж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгоод байна. Ингэснээр албан ёсны статистикийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээг сайжруулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг салбартаа нэвтрүүлж байна.

Бид 2022 онд хэрэглээний үнийн суурийг “Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал”-д заасны дагуу 2018-2020 оны суурьд шилжүүллээ. Түүнчлэн ҮСХ-ны судалгааны чадавхыг бэхжүүлэх зорилгоор МУИС, Эдийн засгийн судалгааны

хүрээлэн, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын судлаач, профессоруудтай хамтарч Агаарын бохирдлын хөдөлмөрийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөөллийн судалгаа, Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаа, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа /нэмэх/, Монгол Улс дахь нийгмийн шилжилт хөдөлгөөний шинжилгээ зэрэг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд илүү хялбар, ойлгомжтой хүргэх зорилтын хүрээнд Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn)) цахим хуудсыг шинэчиллээ. Шинэчилсэн цахим хуудас нь хэрэглэгчид мэдээлэл авахад илүү ойлгомжтой, цэгцтэй хайлтын систем нэвтрүүлснээрээ онцлог боллоо. Түүнчлэн мэдээллийг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй байлгах үүднээс тооллого, судалгааны үр дүн, сарын мэдээний танилцуулга, бюллетень, эмхэтгэл зэргийг видео контент, зурагт хуудас болгон бэлтгэж нийгмийн сүлжээний сувгуудаараа (“Үндэсний Статистикийн Хороо” хуудас, Viber, Telegram, LinkedIn, Twitter, Youtube) тархааж байна. Мөн хэрэглэгчид болон мэдээлэл цуглуулагчид, статистикийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчид, олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газруудын албан хаагчдад чиглэсэн сургалтууд, мэдээллийн цагийг зохион байгуулж, үүнд нийт 1100 орчим хүн хамрагдлаа.

Салбарын цахим шилжилтийн хүрээнд статистик мэдээлэл боловсруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилго бүхий “SPS” системд нийт 36 статистикийн мэдээний маягтыг шилжүүллээ. Энэхүү систем нь статистик тоо мэдээллийг өрх, ААН-ээс цуглуулахаас эхлээд Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn)) дүрсэлж үзүүлэх хүртэлх бүх дамжлагыг цахимжуулснаараа онцлог юм. Түүнчлэн зөөврийн хөдөлгөөнт төхөөрөмж буюу таблетыг бүх төрлийн тооллого, судалгааны мэдээлэл цуглуулалтад ашиглаж эхэллээ. Таблет ашигласнаар мэдээлэл цуглуулах, боловсруулахад зарцуулах хугацааг хэмнэхээс гадна мэдээлэл авсан байршил, хугацаа зэргийг тогтоож мэдээллийн чанарыг хянах боломжтой болсон. Салбарын хэмжээнд “Microsoft Power Automate” программыг бүрэн нэвтрүүлж, албан бичиг, тушаал шийдвэрийн төсөл болон статистик мэдээллийн хяналтыг бүрэн цахимжууллаа. Ингэснээр албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цаасны хэрэглээ эрс багаслаа.

Дээрх ажлуудын үр дүнд 2022 онд, дэлхийн статистикийн байгууллагуудын мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдлыг үнэлдэг “Open Data Watch” байгууллагын үнэлгээгээр 192 орноос VIII, Зүүн Азийн бүс нутагтаа I байранд эрэмбэлэгдэж, 2020 оны үнэлгээнээс 1 шат ахилаа.

Статистикийн салбарыг орчин үеийн өгөгдлийн шинжлэх ухааны суурьтай хөгжүүлэх зорилго бүхий “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн Их Өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил 2021 оноос эхэлсэн. УИХ-ын санаачилгаар хэрэгжүүлж буй энэхүү төсөл Азийн хөгжлийн банкны 1 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжихээр болж, 2022 оны 12 дугаар сард батлагдлаа. Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын хэмжээнд өгөгдлийн засаглал бэхжиж, статистикийн мэдээллийн чанар сайжирч, мэдээллийн зөрүүтэй байдал буурахын зэрэгцээ төр,

хувийн хэвшлийн аливаа шийдвэр гаргалт оновчтой болж, төсөв, хөрөнгө оруулалтын эрсдэлүүд буурах юм.

Бид өнгөрсөн онд гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлд идэвхтэй ажиллалаа. Тухайлбал, НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комисс (АНДЭЗНК)-ын Статистикийн хорооны VIII хурлын даргаар Үндэсний Статистикийн Хорооны дарга сонгогдлоо. Мөн 2021-2023 онд Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийн Бүс дундын шинжээчдийн бүлэг (IAEG-SDG)-ийн Зүүн Азийг төлөөлөх гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Түүнчлэн “21-р зууны Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл”-ийн техник туслалцаагаар Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Бусад орны статистикийн байгууллагатай хамтран ажиллах хүрээнд БНСУ-ын Статистикийн газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Мөн Австрали Улсын Статистикийн Товчоо болон Гүрж Улсын Үндэсний Статистикийн Газартай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар тохиролцоод байна.

Бид 2022 онд ҮСХ-ны хүний нөөц, байгууллагын соёлыг бэхжүүлэх, албан хаагчдад ажлын байрны таатай орчин бүрдүүлэх хүрээнд шинэлэг ажлуудыг санаачлан хэрэгжүүлж эхэллээ. Тодруулбал, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн сургалт, хөтөлбөрүүдэд тогтмол хамруулахаас гадна хамт олны уур амьсгалыг сайжруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх “Нээлттэй мэдээллийн цаг”, “Чөлөөт уулзалт”, “Аз жаргал түгээх мөчүүд” зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна. Мөн салбарын хэмжээнд ажлын байрны дарамтгүй байх зорилт тавьж, энэ талаарх судалгааг улирал тутам явуулж, мэдлэг мэдээлэл олгох сургалт хийж, үр дүнг албан хаагчдад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа юм.

Үндэсний Статистикийн Хороо ирэх 2023 оны хувьд, “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн Их Өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх болон Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа, Цаг ашиглалтын судалгаа зэрэг хуульд заасан түүвэр судалгаануудыг зохион байгуулах томоохон ажлууд хүлээгдэж байна. Үүнээс гадна анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах хүрээнд статистик мэдээллийн бодит байдал, олон улсад харьцуулагдахуйц, уялдаа холбоотой байх нөхцөлийг сайжруулахад голлон анхаарч ажиллана.

ДАРГА



Б.БАТДАВАА

## 2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

1. "Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдөл" төсөл АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр батлагдав.
2. НҮБ-ын АНДЭЗНК-ын Статистикийн Хорооны VIII хурлын даргаар ҮСХ-ны дарга сонгогдов.
3. Статистикийн байгууллагуудын мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлын 2022 оны үнэлгээгээр Монгол Улс 1 байр урагшилж, дэлхийд 8 дугаарт эрэмбэлэгдэв.
4. "Олон улсын өртгийн зэрэгцүүлэлт - 2020" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, дуусгав.
5. Хөдөө аж ахуйн 2022 оны ээлжит улсын тооллогыг газар зүйн мэдээллийн системтэй уялдуулан зохион байгуулав.
6. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг бие даасан хэлбэрээр, Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг Ажиллах хүчний судалгааны хавсарга хэлбэрээр анх удаа зохион байгуулав.
7. Хэрэглээний үнийн сагс, жинг 7 дахь удаагаа шинэчилж, 2020 оны суурьт шилжүүлэв.
8. Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд статистикийн өгөгдөл мэдээллийн сан, түүвэр судалгааны өгөгдөл мэдээлэл цуглуулах, тархаах үзүүлэлтийн уялдааг хангахад мөрдөх багц журмыг шинэчлэн батлав.
9. ҮСХ-ны цахим хуудас, албан ёсны статистикийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэн сайжруулав.
10. Байгууллагын дотоод үйл ажиллагааг цахимжуулав.

## АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



### 2 **ТООЛЛОГО**

Мал тооллого  
Хөдөө аж ахуйн тооллого

### 9 **ТҮҮВЭР СУДАЛГАА**

Хагас жилийн малын түүвэр судалгаа  
Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа  
Ажиллах хүчний болон албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа  
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа  
Ардчилсан засаглал судалгаа  
Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа  
Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа  
Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа  
Тогтвортой 16.7.2 шалгуур үзүүлэлтийг туршилтаар тооцох түүвэр судалгаа

## НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1.1. АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ

Статистикийн арга зүйн шинжлэх ухааны үндэслэл, нэгдмэл байдлыг хангах үүргийг дэлхийн статистикийн системийн хувьд НҮБ-ын Статистикийн комисс, үндэсний түвшинд үндэсний статистикийн байгууллагууд хариуцан ажилладаг. Дэлхийн Банк (ДБ) улс орнуудын статистикийн байгууллагын чадавхыг үнэлдэг үнэлгээний гурван үндсэн үзүүлэлтийн нэг болох арга зүйн үнэлгээгээр 2016 онд 60 оноо авч байсан бол 2020 оны үнэлгээгээр 90 оноо авсан амжилтыг үзүүлээ.

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийг цуглуулж, нэгтгэхэд ҮСХ-ны баталсан болон зөвшөөрсөн 84 аргачлал, 557 маягт, түүнийг нөхөх заавар, 13 ангиллыг мөрдөж байна. НҮБ-аас гишүүн орнуудад зөвлөмж болгосон “Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд”-ын дагуу арга зүйн нэгдмэл байдлыг ханган ажиллаж, салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа 1991-2022 онд батлагдсан 173 арга зүйн баримт бичгийг хамруулан нөхцөл байдлын үнэлгээ хийж, эдгээрээс 131 (76.0%) нь хүчин төгөлдөр мөрдөгдөх, 42 (24%) баримт бичгийг хүчингүй болгох шаардлагатайг тодорхойллоо.

Статистикийн тухай хуульд заасан “Монгол Улсын албан ёсны статистикийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах” үүрэг, “статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх” бүрэн эрхийн хүрээнд статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн баталж, мөрдүүлэх ажлын хүрээнд 2022 онд 7 аргачлал, 9 тооллого, судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 6 багц маягт, түүнийг нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталлаа. Эдгээрээс Байгаль орчин-эдийн засгийн дансны системийн хүрээний дэд данс, Хөдөө аж ахуйн данс байгуулах аргачлал шинээр, Орон сууцны үнийн индексийг хедоник регрессийн аргаар тооцох аргачлал, Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал, Орлого орлуулан тооцох аргаар эрхийн амьжиргааны түвшинг дорхойлох хосолмол аргачлал, Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал, маягт, каталог, Эрчим хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлал, Хөдөө аж ахуйн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал шинэчлэн батлав. (Хавсралт 1).

Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ) болон үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг бий болгох ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ТХЗ-ын 247 үзүүлэлтээс үндэсний түвшинд гаргах боломжтой 132 үзүүлэлтийг ҮСХ болон төрийн бусад байгууллагаас цуглуулсан 2021 оны мэдээллээр шинэчилж, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянах нэгдсэн систем (дашбоард)-д тархаасан. (Хавсралт 2, 3)
- ТХЗ-ын 2.2.3. эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалт, 5.с.1. жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор төсөв

хуваарилах, хянах тогтолцоотой эсэх, 9.b.1. боловсруулах салбарын нийт нэмэгдэл өртөгт дунд болон өндөр технологитой үйлдвэрийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь зэрэг 6 үзүүлэлтийг шинээр тооцсон.

- Шинжлэх ухааны академи, Удирдлагын академитай хамтран Тогтвортой хөгжлийн зорилгын 16.7.2 шалгуур үзүүлэлт /Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт итгэдэг хүн амын хувь/-ийг тооцох туршилт судалгааг 2022 оны 8-9 дүгээр сард утсаар зохион байгуулж, 2021 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхийн 4325 хүнийг хамрууллаа. Туршилт судалгааны өгөгдлийг ӨНЭЗС-ны өгөгдөлтэй холбож, насанд хүрсэн хүн амд тархаан тооцож үр дүнг гаргасан. Ингэснээр Ардчилсан засаглал судалгааны асуулгад асуулт нэмж оруулан уг үзүүлэлтийг тогтмол тооцох боломж бүрдэв.
- АНДЭЗНК-той хамтран “Их өгөгдөл ашиглан байгаль орчин, жендэрийн үзүүлэлтийг тооцох нь” төслийн хүрээнд их өгөгдөл ашиглан ТХЗ 11.1.1-ийг тооцох оролдлогыг хийж, Дэлхийн ажиглалтын мэдээлэл (Earth Observation Data) ашиглан гэр сууцны байршлыг тодорхойлж, үүнийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-гийн өгөгдөлтэй уялдуулан Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн түвшинд хүн ам зүйн үзүүлэлтүүдийг туршилтаар тооцлоо.

## 1.2 СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТООЛЛОГО, ТҮҮВЭР СУДАЛГАА

ҮСХ нь захиргааны болон албан ёсны мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг цуглуулан боловсруулж, тархаан бүх түвшний хэрэглэгчид үнэ төлбөргүй, орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Албан ёсны статистикийн үйл ажиллагааг цахимжуулах, цахим тооллого явуулах, судалгааны мэдээллийг утсаар болон цахим хуудсаар цуглуулах аргыг ашиглах, мэдээллийн чанарыг хангахад онцгой анхаарлаа.

Статистикийн тухай хуульд заасан “албан ёсны статистикийн мэдээлэл, судалгаа, тооллогын үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, мэдээлэх хугацааг тогтоох”, “захиргааны статистикийн мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэлтэй давхардуулахгүй байх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хянах, захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөх, мэдээллийн хамралт, үнэн зөв байдалд үнэлэлт өгөх” бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2022 онд 9 тооллого, судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, статистикийн мэдээний 6 багц маягт, түүнийг нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталлаа.

### 1.2.1 Статистикийн мэдээ

Тайлангийн хугацаанд ҮСХ нь аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраар дамжуулан нийгэм, эдийн засгийн 58 төрлийн мэдээллийг 7 хоног, сар,

улирал, жилийн давтамжтайгаар нэгтгэн боловсруулдаг. Хүнсний гол нэрийн барааны үнийн судалгааг 52 удаа, 17 мэдээг сарын давтамжаар 176 удаа, 18 мэдээг улирлын давтамжтайгаар 70 удаа, 22 мэдээг жилийн давтамжаар 26 удаа цуглуулсан байна.

Статистикийн тухай хуульд заасан “албан ёсны статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн бусад албан газраас тогтоосон хугацаанд авах” бүрэн эрхийн хүрээнд 44 төрийн байгууллагаас 388 төрлийн мэдээг сар, улирал, жилийн давтамжаар 1229 удаа цуглуулж, нэгтгэн гаргаж байна.

ҮСХ нь Статистикийн тухай хууль, НҮБ-ын “Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд”-ын дагуу үндэсний статистикийн системийн хүрээний зохицуулагчийн үүргээ хэрэгжүүлэх хүрээнд бусад төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу албан ёсны статистикийн 12 маягт, захиргааны мэдээллийн 33 маягт, анхан шатны бүртгэлийн 10 маягтыг баталж, зөвшөөрсөн байна.

### 1.2.2 Тооллого, түүвэр судалгаа

ҮСХ нь 2022 онд улсын хэмжээний 2 тооллого, 9 түүвэр судалгааг зохион байгууллаа. Үүний дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа болон Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг анх удаа, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа /нэмэх/, ХБНГУ-ын Цаг уурын хүрээлэнгийн санхүүжилтээр Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа явуулсан нь албан ёсны статистикийн мэдээллийг баяжуулахаас гадна бүх түвшний хэрэглэгчид бодлого боловсруулалт, шийдвэр гаргалт, төлөвлөлтөд ашиглах шинэлэг мэдээллүүдийг бий болгох ач холбогдолтой ажил боллоо.

### ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГО

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран 10 жил тутамд явагддаг хөдөө-аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгууллаа. Тооллогын мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 5 дугаар сарын 21-ээс 7 дугаар сарын 8-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 297.0 мянган өрх, 2.9 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан.

Тооллогын мэдээлэл цуглуулалтад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гишүүн орнуудад зөвлөмж болгосон “Хөдөө аж ахуйн дэлхийн хөтөлбөр”-т заасан нэгдсэн аргачлал, үзүүлэлт, зөвлөмжийн дагуу Хөдөө аж ахуйн тооллогын зохион байгуулалтыг нэлэнхий болон түүвэр судалгааны аргыг хослуулан ашиглаж, 10 жилийн өмнөх тооллогын үндсэн үр дүн, олон улсын түвшинд харьцуулах боломжтой өгөгдлийг цуглуулав. Нүүр тулсан ярилцлагыг таблет ашиглан зохион байгуулсан бөгөөд өндөр нарийвчлалтай сансрын зургийн



мэдээллээр тариалангийн талбайн байршил, өрх, ААНБ-ын байршлын цэгийг тэмдэглэснээрээ өмнөх тооллогоос онцлог байлаа.

### Хөдөө аж ахуйн тооллогын үр дүнгээс

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцэст 920.2 мянган өрх бүртгэгдсэнээс 507.6 мянган өрх аймаг, орон нутагт буюу сумдад амьдарч байна. 2011 онтой харьцуулахад нийт өрхийн тоо 21.1 хувиар, орон нутагт амьдарч байгаа өрхийн тоо 12.0 хувиар өссөн байна. ХАА-н тооллогод 2021 онд 297.0 мянган өрх, аж ахуй нэгж бүртгэгдсэн нь 2011 оноос 51.5 мянган өрх, аж ахуй нэгж байгууллага буюу 21.0 хувиар өссөн байна.

### ХҮСНЭГТ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ам бүлийн тоо, мянган хүнээр

	Бүгд		Мал аж ахуй		Газар тариалан	
	2011	2021	2011	2021	2011	2021
Өрх	243.1	264.2	209.6	245.4	33.5	18.8
Өрхийн хүн ам	929.2	737.0	795.4	688.4	133.8	48.6
Үүнээс: 16 Хүртэлх насны хүүхэд	293.2	188.2	257.9	178.1	36.0	10.1
Нэг өрхийн дундаж ам бүл	3.8	2.8	3.8	2.8	4.0	2.6

Тооллогын дүнгээс харахад ХАА-н салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйлүүд 10 жилийн өмнөх үзүүлэлтүүдээс дорвитой өөрчлөлтгүй буюу хүндрэл бэрхшээлтэй хэвээр ажиглагдсан. Тухайлбал ажиллах хүчний дутагдал ихтэй байгаа ба орон нутагт ажиллах хүний нөөц хомс, байнгын болон түр ажиллагч олдохгүй байдал, газар тариалангийн тоног төхөөрөмжийн шинэчлэл удаан хийгддэг буюу дундаж ашигласан жил 10.8 байна.

### ЗУРАГ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар



Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн зөвхөн 3.6 хувь тариалангийн талбайдаа агрохимийн шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээ хийсэн өрхүүдийн хөрсний элэгдэл, эвдрэлийн зэрэг хэвийнээс сул руу, сулаас дундаж руу шилжсэн хандлага эрдсийн төрөл тус бүрд ажиглагдсан байна. Түүнчлэн тариалангийн талбай нь тэжээл болон органик бодис, давслаг, ислэг, шүлтлэгээ алдсантай холбоотой хөрсний химийн чанар болох хөрсний нитратын азот, хөрсний хөдөлгөөнт фосфор, хөрсний хөдөлгөөнт кали буурах буюу бохирдох үзэгдэл нэмэгдэж байгааг харуулжээ.

МАН-н үйлдвэрлэл эрхэлдэг өрх, ААНБ-ын хувьд бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой хүндрэл, бэрхшээл ихээхэн гардаг нь тооллогын дүнгээр ажиглагдсан. Тухайлбал, МАН эрхэлдэг өрхүүдийн 53.7 хувь нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд өөрсдөө борлуулдаг, 52.0 хувь нь үйлдвэрлэлийн нэгжээсээ худалдаа эрхлэгчдэд шууд худалддаг, 2.5 хувь нь ААНБ-д шууд, 0.9 хувь нь бусад хэлбэрээр борлуулж байна. Хэрэглэгч цөөн, бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай, зах зээлээс алслагдсан зэрэг хүндрэлүүд 13.4-74.5 хувь байгаа нь 2011 оныхоос 6.3-27.1 нэгж хувиар өссөн байна.

### Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого

Мал, тэжээвэр амьтдын 2021 оны жилийн эцсийн тооллогын үр дүнг нэгтгэн боловсруулж, 2022 оны 1 дүгээр сард Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганд танилцуулсан. Тооллогын мэдээллийн санг Монголбанк, ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, ХНХЯ, Архивын ерөнхий газар, И-Монголиа академи зэрэг байгууллагад хүлээлгэн өгөв.

Жилийн эцсийн мал тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 7-17 хооронд явуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 71.1 сая толгой мал тоологдож, тооллогын дүнг нийтэд мэдээллээ.

#### Мал, тэжээвэр амьтдын тооллогын үр дүнгээс

Улсын хэмжээгээр 2022 оны эцсийн мал тооллогоор 71.1 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 3.8 сая (5.6%)-аар өслөө. Үүнээс адуу 4.8 сая, үхэр 5.5 сая, тэмээ 470.5 мянга, хонь 32.7 сая, ямаа 27.6 сая байна. Өмнөх онтой харьцуулахад хонь 1.7 сая (5.3%), үхэр 0.5 сая (9.8%), адуу 0.5 сая (11.5%), ямаа 1.1 сая (4.2%), тэмээ 16.4 мянга (3.6%)-аар тус тус өссөн байна. Нийт мал сүрэгт хонь 46.0 хувь, ямаа 38.8 хувь, үхэр 7.8 хувь, адуу 6.8 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж байна.

#### ХҮСНЭГТ 2. МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР, САЯ ТОЛГОЙ, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ

Малын төрөл	2019	2020	2021	2022	Өөрчлөлт	
					тоо толгой	хувь
Нийт	71.0	67.1	67.3	71.1	3.8	105.6
Адуу	4.2	4.1	4.3	4.8	0.5	111.5
Үхэр	4.8	4.7	5.0	5.5	0.5	109.8
Тэмээ	0.5	0.5	0.5	0.5	0.0	103.6
Хонь	32.3	30.0	31.1	32.7	1.7	105.3
Ямаа	29.3	27.7	26.5	27.6	1.1	104.2

Мал тооллогын 2022 оны дүнгээр нийт малтай өрхийн (248.3 мянга) 76.8 хувь буюу 190.8 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа малчин өрх байна. Малчин нэг өрхөд ногдох малын тоо 2022 онд дунджаар 339 болж, өмнөх оноос 16 толгой мал буюу 5.0 хувиар өссөн байна. Малчин нэг өрхөд 22 адуу, 25 үхэр, 2 тэмээ, 157 хонь, 132 ямаа ногдож байна. Мал тооллогын 2022 оны дүнгээр 305.1 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Малчдын насны бүлэгт 18-34 насныг хэрэв залуу малчид гэж үзвэл нийт малчдын 26.6 хувийг эзэлж байна.

Энэ үзүүлэлт 2000 онд 56 хувь байсантай харьцуулахад малчдын дунд залуу малчдын эзлэх хувь багассаар байгааг илтгэж байна. Түүнчлэн, 18-34 насны огт гэрлээгүй малчдын 87.0 хувь нь эрэгтэй 13.0 хувь нь эмэгтэй байна.

## ЗУРАГ 2. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТ, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар




## Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын нэгдсэн үр дүн

Үндэсний Статистикийн Хороо нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлыг тогтоож, тэдгээрийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, бодлого, шийдвэрт шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой аж ахуйн нэгжийн 7 дахь удаагийн тооллогыг зохион байгуулж, үр дүнг боловсруулж, нийтийн хүртээл болгов.

### Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын нэгдсэн үр дүнгээс

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод 180.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ), 53.9 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч (ХХЭ)-ийг хамруулсан бөгөөд ААНБ-ын тоо 2016 оны тооллогын дүнгээс 61.3 мянга (51.7%)-аар, 2011 оны тооллогын дүнгээс 114.8 мянга (2.8 дахин)-аар, 2006 оны тооллогын дүнгээс 147.6 мянга (5.6 дахин)-аар, 1998 оны тооллогын дүнгээс 161.1 мянга (9.5 дахин)-аар тус тус нэмэгдсэн байна.

### ЗУРАГ 3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, тооллого явагдсан оноор




Нийт ААНБ-ын 151.6 мянга (84.2%) нь аж ахуйн нэгж, 4.6 мянга (2.6%) нь төсвийн байгууллага, 23.9 мянга (13.3%) нь төрийн бус байгууллага байна.

ЗУРАГ 4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ТОО, төрлөөр, 2021 он



ААНБ-ын тоогоор Улаанбаатар хот тэргүүлж, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь зэрэг аймгууд удаалж байна.

ЗУРАГ 5. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАРХАЛТ, аймаг, нийслэлээр, 2021 он



Нийслэл Улаанбаатар хотод 130.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага тоологдсон нь 2016 оны тооллогын дүнгээс 44.7 мянга (52.4%)-аар өсжээ. Аж ахуйн нэгжийн тоо 2021 оны тооллогоор 151.6 мянга болж, 2016 оны тооллогоос 50.1 мянга (49.4%)-аар, төсвийн байгууллагын тоо 4.6 мянгад хүрч, 0.2 мянга (5.1%)-аар, төрийн бус байгууллагын тоо 23.9 мянга болж, 11.0 мянга (85.6%)-аар тус тус

нэмэгджээ.

ХҮСНЭГТ 3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, төрөл, тооллого явагдсан оноор

Он	Бүгд	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага
1998	18 950	14 040	3 835	1 075
2006	32 410	26 841	3 398	2 171
2011	65 204	55 366	3 959	5 879
2016	118 686	101 463	4 372	12 851
2021	180 006	151 557	4 597	23 852


ААНБ-ын 75.4 мянга (41.9%) нь үйлчилгээний салбарт, 66.8 мянга (36.6%) нь худалдааны салбарт, 16.3 мянга (9.0%) нь аж үйлдвэрийн салбарт, 13.9 мянга (7.7%) нь барилгын салбарт, 8.5 мянга (4.7%) нь хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

**ХҮСНЭГТ 4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, 2016, 2021 он**

Үйл ажиллагааны чиглэл	2016		2021		2021 / 2016	
	Тоо	%	Тоо	%		%
Бүгд	118 686	100.0	180 006	100.0	151.7	
Хөдөө аж ахуй	6 263	5.3	8 544	4.7	136.4	
Аж үйлдвэр	10 139	8.5	16 285	9.0	160.6	
Барилга	10 649	9.0	13 885	7.7	130.4	
Худалдаа	44 871	37.8	65 847	36.6	146.7	
Үйлчилгээ	46 764	39.4	75 445	41.9	161.3	

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 56.8 мянга буюу 37.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа, харин 94.7 мянга нь үйл ажиллагаагаа тодорхой шалтгааны улмаас явуулаагүй байна.

**ЗУРАГ 6. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, тооллого явагдсан оноор**



Манай Улсад бүртгэлтэй төрийн бус байгууллагын дийлэнх нь төрд тавих хяналтыг сайжруулах буюу нийгэмд үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ чиглэлийн төрийн бус байгууллагын тоо сүүлийн 5 жилд 1.8 дахин өссөн байна.

**ЗУРАГ 7. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТОО, төрөл, тооллого явагдсан оноор**



Энэ удаагийн тооллогоор 53.9 мянган ХХЭ тоологдсоны 25.2 мянга (46.7%) нь эрэгтэйчүүд, 28.7 мянга (53.3%) нь эмэгтэйчүүд байна. ХХЭ-дийн 26.3 мянга (48.8%) нь Улаанбаатар хотод, 8.4 мянган (15.6%) нь Төвийн бүсэд, 8.2 мянга (15.2%) нь Хангайн бүсэд, 7.9 мянга (14.7%) нь Баруун бүсэд, 3.1 мянга (5.7%) нь Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.

**ХҮСНЭГТ 5. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, бүс, аймаг, нийслэл, хүйсээр**

Бүс, аймаг, нийслэл	Бүгд	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй
<b>Бүгд</b>	<b>53 927</b>	<b>25 199</b>	<b>28 728</b>
<b>Баруун бүс</b>	<b>7 942</b>	<b>4 504</b>	<b>3 438</b>
Баян-Өлгий	1 936	1 384	552
Говь-Алтай	987	473	514
Завхан	1 714	860	854
Увс	1 418	849	569
Ховд	1 887	938	949
<b>Хангайн бүс</b>	<b>8 187</b>	<b>3 692</b>	<b>4 495</b>
Архангай	953	519	434
Баянхонгор	874	456	418
Булган	301	114	187
Орхон	3 078	1 178	1 900
Өвөрхангай	1 429	648	781
Хөвсгөл	1 552	777	775
<b>Төвийн бүс</b>	<b>8 386</b>	<b>3 955</b>	<b>4 431</b>
Говьсүмбэр	338	126	212
Дархан-Уул	2 117	899	1 218
Дорноговь	1 248	571	677
Дундговь	560	261	299
Өмнөговь	625	261	364
Сэлэнгэ	1 685	800	885
Төв	1 813	1 037	776
<b>Зүүн бүс</b>	<b>3 073</b>	<b>1 412</b>	<b>1 661</b>
Дорнод	960	418	542
Сүхбаатар	1 046	519	527
Хэнтий	1 067	475	592
<b>Улаанбаатар</b>	<b>26 339</b>	<b>11 636</b>	<b>14 703</b>

**Хагас жилийн малын түүвэр судалгаа**

Хагас жилийн малын түүвэр судалгааг Хөдөө аж ахуйн 2022 оны ээлжит тооллоготой хамт 2022 оны 5-7 сард зохион байгуулж, үр дүнг нэгтгэн боловсрууллаа.

Түүвэр судалгаанд 2021 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан нийт ерх, аж ахуйн нэгж, байгууллагын 30 хувь буюу 75011 нэгжийн 95.6 хувь буюу 71698 нэгж судалгаанд хамрагдсан бөгөөд 2022 оны эхний хагас жилд 83.6 сая толгой мал тоологдож, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар буюу 4.2 саяар өссөн байна. Нийт 3 аймаг, 7 сумын малын хорогдол босго давсан байна.

**Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)**


Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлох, жил бүр өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индексэд ашигладаг сагс болон жинг шинэчлэх, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай мэдээллийг гаргах үндсэн зорилготой юм.

ӨНЭЗС-ны 2021 оны жилийн эцсийн болон 2021 оны 4, 2022 оны 1, 2, 3-р улирлын мэдээллийн санг нэгтгэн улирал болон жилийн түүврийн жинг тооцон, үр дүнгийн тооцоолол хийн, улирлын танилцуулга, жилийн тайланг хэрэглэгчдийн хүртээл болголоо. Мөн Дэлхийн банктай хамтран ядуурлын тооцооны шинэ загвар гаргаж, 2020 оны ядуурлын тооцоог улс, хот, хөдөө, суурьшил, аймгийн түвшинд хийж, үр дүнг хэрэглэгчдэд тархаасан. ӨНЭЗС-ны 2022 оны 1-4 дүгээр улирлын бюллетень, танилцуулгыг бэлтгэн хэрэглэгчдэд хүргэсэн.

ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулалтад 123 мэдээлэл цуглуулагч, 22 ахлагч, 3 хянагч ажилладаг бөгөөд 2022 онд 2206 түүврийн нэгжийн 17730 өрхөөс мэдээллийг таблетаар (CAPI) цуглуулж, өрхийн тэмдэглэл хөтлүүлэн өдөр тутмын хүнсний хэрэглээний мэдээллийг нэгтгэн гаргасан.

### Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны үр дүнгээс

**ЗУРАГ 8. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр**



Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлогын хэмжээ 2022 оны 4 дүгээр улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.4 (0.7%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 20.4 (1.7%) мянган төгрөгөөр буурчээ. Бодит нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурахад тэтгэвэр, тэтгэмжийн бодит орлого 51.1 (15.7%) мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлжээ.

**ЗУРАГ 9. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр**



Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 2022 оны 4 дүгээр улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 92.5 (8.6%) мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх улирлаас 19.6 (1.6%) мянган төгрөгөөр буурчээ. Бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 71.8 (10.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 6. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, улсын дунджаар**

Орлогын төрөл	2019	2020	2021	2022	
	X-XII	X-XII	X-XII	VII-IX	X-XII
<b>Нийт орлого</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>1. Мөнгөн орлого</b>	<b>91.7</b>	<b>92.7</b>	<b>92.8</b>	<b>92.9</b>	<b>93.9</b>
Цалин хөлс	49.9	50.1	42.9	48.1	50.7
Тэтгэвэр, тэтгэмж	16.7	22.2	28.1	23.3	23.9
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	9.6	7.0	9.5	6.7	6.4
Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	6.7	5.2	4.2	6.1	5.5
Бусад орлого	8.8	8.2	8.1	8.7	7.4
<b>2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>4.4</b>	<b>3.1</b>	<b>2.7</b>	<b>3.2</b>	<b>2.6</b>
<b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>3.9</b>	<b>4.2</b>	<b>4.5</b>	<b>3.9</b>	<b>3.5</b>

Өрхийн сарын дундаж нийт орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 7.8 нэгж хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 1.3 нэгж хувиар нэмэгдэж, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 4.2 нэгж хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь 3.1 нэгж хувиар, бусад орлогын эзлэх хувь 0.7 нэгж хувиар буурсан байна.

**ХҮСНЭГТ 7. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, зарлагын төрөл, улсын дунджаар**

Зарлагын төрөл	2019	2020	2021	2022	
	X-XII	X-XII	X-XII	VII-IX	X-XII
<b>Нийт зарлага</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>1. Мөнгөн зарлага</b>	<b>92.1</b>	<b>92.9</b>	<b>92.3</b>	<b>93.0</b>	<b>94.1</b>
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	18.9	19.9	20.4	20.5	19.0
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	62.7	63.4	61.9	61.5	63.1
Бусад зарлага	8.7	7.9	8.1	9.3	9.9
Бусдад өгсөн бэлэг, тусламж	1.8	1.7	1.9	1.7	2.1
<b>2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>4.2</b>	<b>3.0</b>	<b>2.8</b>	<b>3.1</b>	<b>2.5</b>
<b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>3.7</b>	<b>4.1</b>	<b>4.9</b>	<b>3.9</b>	<b>3.4</b>

Өрхийн сарын дундаж нийт зарлагад хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувь 2022 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурч, харин хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын эзлэх хувь 1.2 нэгж хувиар, бусад зарлагын эзлэх хувь 1.8 нэгж хувиар, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагын эзлэх хувь 0.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.



## Ажиллах хүчний болон албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Ажиллах хүчний судалгаа (АХС) нь хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг гаргадаг чухал эх үүсвэр бөгөөд уг судалгааны хавсарга судалгаа хэлбэрээр албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг анх удаа Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын арга зүй, техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан нь манай улсын хэмжээнд байгаа албадан хөдөлмөрийн хэлбэрүүдийг тодорхойлох, энэ талаарх мэдээлэл бий болгоход чухал ач холбогдолтой болсон.

Ажиллах хүч болон албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааг зохион байгуулахад 123 мэдээлэл цуглуулагч, 22 ахлагч, 3 хянагч ажиллаж, 1552 түүврийн нэгжийн 15520 өрхөөс мэдээллийг таблетаар (CAPI) цуглууллаа.

АХС-ны 2021 оны жилийн эцсийн болон 2021 оны 4, 2022 оны 1, 2, 3-р улирлын мэдээллийн санг нэгтгэн улирал болон жилийн түүврийн жинг тооцон, үр дүнгийн тайлан, танилцуулга бэлтгэн нийтийн хүртээл болголоо.

Судалгааны үр дүнгээс хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтүүдийг улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд тооцож улирал, жилээр тогтмол тархаадаг. Уг судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд улирал, жилээр үр дүнг тооцон 2022 оны 1-4 дүгээр улирлын бюллетень, танилцуулгыг бэлтгэн, хэрэглэгчдэд хүргэлээ.

### Ажиллах хүчний судалгаа (АХС)-ны үр дүнгээс

#### ЗУРАГ 10. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, улирлаар, мянган хүн

	2020	2021-I	2021-II	2021-III	2021-IV	2021	2022-I	2022-II	2022-III	2022-IV
Ажиллагчид	1162.9	1054.9	1105.7	1135.9	1127.1	1125.6	1128.4	1164.9	1191.5	1158.3
Ажилгүй хүн	87.7	101.2	101.3	90.9	99.4	99.8	104.4	98.5	68.1	64.6
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	877.5	949.7	917.0	893.8	878.2	926.8	892.8	865.4	866.9	888.2

Ажиллах хүчний судалгааны 2022 оны 4-р улирлын үр дүнд улсын хэмжээнд ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 3.6 мянган хүнээр буюу 0.3 хувиар буурч, ажиллах хүчний оролцооны түвшин 0.4 нэгж хувиар буурч 57.9%-д хүрсэн байна.

Ажиллагчид өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.1 мянга буюу 2.8 хувиар өссөн байна. Уг өсөлтөд боловсруулах үйлдвэрлэлд ажиллагчид 24.6 (30.1%) мянгаар, хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид 13.0 (4.7%) мянгаар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн цалин хөлстэй түр ажиллагч 123.2 (44.5%) мянгаар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Ажилгүй хүний тоо 2022 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 34.8 (35.0%) мянгаар, өмнөх улирлаас 3.5 (5.1%) мянгаар буурсан байна. Шалтгаанаар авч үзвэл, 28.0% нь ажил хайгаад олдохгүй байгаа, 14.0% нь улирлын шинж чанартай хөдөлмөр эрхэлдэг, 13.0% нь мэргэжил, дадлага, туршлага байхгүй гэж хариулсан байна.

**ЗУРАГ 11. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар**



Ажиллах хүчний оролцооны түвшин 2022 оны 4 дугаар улиралд өмнөх улирлаас 1.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх улирлаас 1.1 нэгж хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар өссөн байна.

**ЗУРАГ 12. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар**



Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх үзүүлэлтүүд өмнөх улиралтай харьцуулахад, хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 0.2 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 0.1 нэгж хувиар, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 0.4 нэгж хувиар буурч, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 0.1 нэгж хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин тус тус 2.6 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 2.8 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 2.9 нэгж хувиар буурсан байна.



## Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (ХХС) нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, тархалтыг газар зүйн байршлаар, өрхийн төрөл, шинж байдлаар, хүүхдийн сургуульд хамрагдалтын байдал, хүйс, насны бүлэг болон бусад хүчин зүйлсээр тооцон судлах зорилготой судалгаа юм.

ҮСХ нь ХХС-г 2002-2003, 2006-2007, 2011-2012 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын техник, санхүүгийн дэмжлэгээр АХС-ны хавсарга судалгаа хэлбэрээр зохион байгуулж байсан. Харин 2022 онд Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг анх удаа бие даасан судалгаа болгон зохион байгууллаа. ХХС-ны мэдээлэл цуглуулалтад нийслэл, орон нутгийн 51 мэдээлэл цуглуулагч, 22 ахлагч, 3 хянагч ажиллаж, 1104 түүврийн нэгжийн 13248 өрхөөс таблетаар (CAPI) мэдээлэл цуглуулсан. Судалгааны урьдчилсан үр дүнг тооцон, тооцооллыг баталгаажуулах зорилгоор ОУХБ-д хүргүүлээд байна.

## Ардчилсан засаглал судалгаа

Ардчилсан засаглал судалгаа (АЗС)-г 2008 оны III улирлаас эхлэн явуулж байгаа бөгөөд судалгааны зорилго нь Тогтвортой Хөгжлийн Зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Чанартай боловсролыг дэмжих” 4 дүгээр зорилго, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” 5 дугаар зорилго, “Энх тайван, шударга ёсыг цогцлоох” 16 дугаар зорилго, “Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх” 17 дугаар зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх зарим шалгуур үзүүлэлтүүдийг улс, бүс нутгийн түвшинд тодорхойлох юм. Энэ судалгаанд ҮСХ-ноос тогтмол явуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд хамрагдсан өрхийн 15, түүнээс дээш насны хоёр гишүүнийг хамруулдаг.

ӨНЭЗС-нд 2022 оны 2, 5, 8, 11 дүгээр сард сонгогдсон өрхүүдээс нийт 2552 өрхийг түүвэрлэн сонгож, эдгээр өрхөд амьдарч буй 15, түүнээс дээш насны өрхийн гишүүдийн жагсаалтаас санамсаргүй тооны Кишийн хүснэгтийн аргыг ашиглан судалгаанд хамрагдах хүнийг сонгож мэдээлэл цуглууллаа.

Ардчилсан засаглал судалгааны үр дүнгээр тайлан бэлтгэн нийтийн хүртээл болгов.

## Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа

ҮСХ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан (НҮБХҮС)-гийн захиалгаар “Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа”-г 2022 оны 3, 4 дүгээр улиралд Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймгуудад зохион байгуулж, эдгээр аймагт амьдарч буй өрхүүд эрүүл аюулгүй орчинд амьдарч чадаж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

Судалгаанд 1872 өрх хамрагдаж, 140 мэдээлэл цуглуулагч ажиллалаа. Мэдээллийн сан бүрдүүлэн, үр дүнг тооцож 2019-2022 оны үр дүнгийн харьцуулсан тайлан бэлтгэн НҮБХҮС-д хүлээлгэн өгсөн.

## **Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа /нэмэх/**

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр явуулсан хүүхэд, өрх, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдыг хэрэгцээтэй мэдээллээр шуурхай хангах зорилготой Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа /нэмэх/-г 2020-2022 онд зохин байгууллаа. Уг судалгаанд хамрагдсан 2200 өрхөөс 8 шатны мэдээлэл цуглуулсан.

Уг судалгааг 2022 онд 2600 өрхийг хамруулан зохион байгуулж, 3 шатны мэдээллийг ҮСХ-ны дуудлагын төвөөр дамжуулан утсаар /CATI / цуглуулж, үр дүнг Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn)) цахим хуудсанд байршуулж, нийтийн хүртээл болголоо.

## **Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа**

Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгааны 4, 5 дахь шатны мэдээлэл цуглуулалтын ажлыг гүйцэтгэж, мэдээллийн санг ХБНГУ-ын судалгааны багт бүрэн хүлээлгэн өгч, судалгааны үр дүнгээр 4 тайланг урьдчилсан байдлаар англи хэл дээр бэлтгэв.

## **Тогтвортой хөгжлийн зорилгын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг (Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдагт итгэдэг хүн амын хувь) туршилтаар тооцох түүвэр судалгаа**

Шинжлэх ухааны академи, Удирдлагын академийн хүсэлтээр ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг (Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдагт итгэдэг хүн амын хувь) туршилтаар тооцох түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 16 өдрүүдэд 2021 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхийн 4325 хүнийг хамруулан ҮСХ-ны дуудлагын төвөөр дамжуулан утсаар буюу CATI технологиор зохион байгууллаа. Хариулагчийн өгсөн мэдээллийг ӨНЭЗС-ны өгөгдөлтэй холбож үр дүнг тооцсон. Энэхүү туршилт судалгааг хийснээр Ардчилсан засаглал судалгааны 2023 оны асуулгад уг үзүүлэлтийг тооцох асуулт шинээр нэмж оруулан, үзүүлэлтийг байнга тооцох боломжийг бүрдүүлэв.

## **Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаа**

Судалгааны зорилго нь богино хугацааны хөдөлгөөнд орсон иргэдийн шалтгаан, хөдөлмөр эрхлэлт, тухайн орон нутагт тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг судлах замаар Монгол Улс дахь богино хугацааны хөдөлгөөнд оролцсон иргэдэд зориулсан бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоход шаардлагатай мэдээллийг бий болгох явдал байв. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд зохион байгуулж, нийслэл, 21 аймгийн 1640 баг, хорооны засаг дарга нараас мэдээллийг цаасаар (PAPI) цуглуулсан.

### Судалгааны үр дүнгээс

Богино хугацааны хөдөлгөөнд оролцогчдыг бүртгэл хийлгэдэг, бүртгэл хийлгэдэггүй шалтгааныг асуухад түр зуур оршин сууж байгаа болохоор бүртгүүлэхийг хүсдэггүй гэж (23.6%), шалтгаан байхгүй (17.1%), хэрхэн бүртгүүлэхээ мэдэхгүй (15.4%), бүртгэл хийлгээд ямар нэг ашиг тус байхгүй (13.7%), боловсролын шалтгаанаар (10.0%), хэтэрхий төвөгтэй, хугацаа их шаарддаг (5.9%) гэж хариулсан ба тэдгээрийн 3.2-5.6% нь иргэний бүртгэлийн газраас хол байдаг, хэт их мэдээлэл шаарддаг гэж үзсэн бол үлдсэн 5.4% нь өөр бусад шалтгаанаас болсон гэж хариулт өгсөн байна.

### ЗУРАГ 13. БҮРТГЭЛЭЭ ХИЙЛГЭДЭГГҮЙ ГОЛЛОХ ШАЛТГААН, хувиар, 2022 он



Мөн судалгааны нэг чухал үзүүлэлт нь иргэдийн орлогын эх үүсвэрийг тодорхойлох байсан. Багийн засаг дарга нар багийнхаа иргэдийн орлогын эх үүсвэрийг өөрсдийн бодлоор дүгнэхдээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс 61.5 хувь, цалин хөлсний орлогоос 22.7 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн орлогоос 7.4 хувь, газар болон байрны түрээсийн орлого, гэр бүл, найз нөхдөөс илгээсэн мөнгөн тусламж 0.1 хувь, төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж, тэтгэврийн орлогоос 0.1-1.0 хувийг олдог гэж хариулсан бол үлдсэн 7.0 хувь нь эдгээрээс бусад өөр эх үүсвэрээс гэж хариулжээ.

### Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжих хөдөлгөөний туршилтын судалгаа


Хүн амын Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжих хөдөлгөөний шинж байдал, шилжин суурьшсан нутаг дахь шилжигчдийн нөхцөл байдлыг судлах зорилгоор энэхүү судалгаа хийсэн.

Монгол Улсын 21 аймгийн хэмжээнд 2520 өрхөөс мэдээллийг утсаар (CATI) цуглуулсан. Судалгааг тоон судалгаа болон зорилтод бүлгийн аргаар 2022 оны 9 сарын 22-ноос 26-ны өдрүүдэд зохион байгуулсан.

### Судалгааны үр дүнгээс:

Судалгаагаар, 2017-2021 оны хооронд Улаанбаатараас орон нутагт шилжин суурьшсан өрхүүдэд нийт 53327 хүн ам амьдарч байна. Үүний 28030 нь хөдөлмөрийн буюу 16-59 насны, 21875 нь 0-15 насны хүүхэд, 3422 нь тэтгэврийн буюу 60, түүнээс дээш насны иргэд байна.

**ЗУРАГ 14. СҮҮЛИЙН 5 ЖИЛД НИЙСЛЭЛЭЭС ОРОН НУТАГ РУУ ШИЛЖИН СУУРЬШИГЧ ӨРХҮҮД ДЭХ ХҮН АМЫН ТОО, нас, хүйсийн бүтцээр**



Тоон судалгаагаар, шилжих хөдөлгөөний үр дүнд шилжигчдийн амьдралд ямар өөрчлөлт гарсныг судлахдаа 14 үзүүлэлтийн хувьд шилжигчдээр өөрсдөөр нь “дордсон”, “хэвэндээ”, “сайжирсан” гэсэн үнэлгээнүүдээс сонгуулан үнэлсэн. Шилжигчдийн дийлэнх нь ихэнх үзүүлэлтэд шилжилтийн дараа “онцлох өөрчлөлт гараагүй, хэвэндээ” гэж үнэлсэн байна. Гэхдээ нийт 14 үзүүлэлтээс 2 үзүүлэлтийн хувьд шилжигчдийн 50-аас дээш хувь нь “сайжирсан” гэж үнэлсэн ба бүх үзүүлэлтийн хувьд “дордсон” гэсэн үнэлгээ өгсөн хариулагчид харьцангуй бага жинтэй байна.


Нийслэлд байсан үеийнхтэй нь харьцуулбал “сайжирсан” буюу зөргөөр өөрчлөгдсөн гэж үзэж буй үзүүлэлтүүдийн жагсаалтыг шинэ газарт амьдрах болсноор байгаль, экологийн орчин нөхцөл сайжирсан гэх үзүүлэлт 78.5 хувьтайгаар тэргүүлсэн байна. Үүний дараа, шилжигчдийн сэтгэл санааны байдал сайжирсан (65.3 хувь), хамаатан, найз нөхөд, хөршийн хүрээлэл сайжирсан (43.4 хувь), гэр бүлийн харьцаа сайжирсан (29.5 хувь) гэсэн үзүүлэлтүүд орж байна. Бусад үзүүлэлтийн хувьд шилжигчдийн 11.5-25.3 хувь нь л “сайжирсан” гэж үзэж байна. Шилжин ирснээс хойш “дордсон” буюу сөргөөр өөрчлөгдсөн зүйлсийн хувьд, зах зээлийн худалдан авах, худалдах боломж дордсон (35.3 хувь), нийтийн тээврийн хэрэглээ дордсон (24.6 хувь), чөлөөт цаг өнгөрөөх байдал дордсон (18.0 хувь) гэсэн үзүүлэлтүүд тэргүүлж байна. Бусад үзүүлэлтийн хувьд шилжигчдийн 1.5-12.9 хувь нь “дордсон” гэсэн үнэлгээг өгсөн байна.

**ЗУРАГ 15. АМЬДРАЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ НИЙСЛЭЛД БАЙСАН ҮЕИЙНХЭЭС ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДСӨН ТАЛААРХ ШИЛЖИГЧДИЙН СЭТГЭГДЭЛ**



Мөн Дөрвөн шилжигч тутмын гурав нь Улаанбаатараас орон нутаг руу шилжин суурьшсандаа “маш их”, “их” сэтгэл ханамжтай гэсэн ба 22.9 хувь нь “дунд”, 1.5 хувь нь “бага” сэтгэл ханамжтай, 0.4 хувь нь “огт ханамжгүй” гэж хариулсан байна. Шилжин суурьшсан бүс, байршлаар задлан харвал ялгаа бага байгаа ч “маш их/их” сэтгэл ханамжтай гэсэн шилжигчид баруун бүсэд шилжсэн мөн сумын төвд суурьшсан шилжигчдийн дунд бусад бүлгийнхнээс арай цөөн байв. Шилжилтийн талаарх сэтгэл ханамжийн байдал шилжигчдийн шилжин ирсэн он, өрхийн ам бүлийн тоо, өрх дэх 0-15 насны хүүхдийн тоо, шилжигчийн нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдал зэргээр статистик ач холбогдол бүхий ялгаагүй байсан.

**ЗУРАГ 16. НИЙСЛЭЛЭЭС ОРОН НУТАГТ ШИЛЖИН СУУРЬШСАН 18+ НАСНЫ ИРГЭДИЙН ХУВЬ, шилжилтийн талаарх сэтгэл ханамжийн түвшнээр, бүсээр, байршлаар.**



## 1.3 ТООЦОО, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

### 1.3.1 Суурь тооцоо

#### Үндэсний тооцооны систем, Байгаль орчин-эдийн засгийн дансны системийн хүрээнд хийсэн тооцоо

Үндэсний тооцооны систем болон байгаль орчин-эдийн засгийн дансны систем (БОЭЗДС)-ийн нэвтрэлтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд ДНБ, ҮНО-ын жил, улирлын гүйцэтгэлийн тооцоолол, танилцуулгыг бэлтгэж, 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр дараах тооцоолол, танилцуулгыг бэлтгэн хэрэглэгчдэд хүргэлээ.

#### Тооцооны үр дүнгээс


Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2022 онд оны үнээр 52.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 9.3 (21.4%) их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 28.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.3 (4.8%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.

#### ЗУРАГ 17. ДНБ-ИЙ ХЭМЖЭЭ, их наяд төгрөгөөр



ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2021 онд өмнөх оноос 1.6 хувиар нэмэгдсэн бол 2022 онд 4.8 хувиар өслөө.

#### ЗУРАГ 18. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар (2015 оны зэрэгцүүлэх үнээр)



## Хэрэглээний үнийн суурь, жин, сагсны шинэчилсэн тооцоо

Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлалд хэрэглээний үнийн суурийг 5 жилийн давтамжтайгаар шинэчлэхээр заасны дагуу 2015 оны суурийг шинэчилж, 2020 оны суурьд шилжүүлэв. Хэрэглээний үнийн индекс тооцооны жинг өрхийн хэрэглээний зарлагын 2020 оны дүнд үндэслэн тооцоход цар тахлын нөлөө гарч, хэвийн жилүүдийнхээс өөрчлөлттэй байсан тул уг нөлөөг багасгах үүднээс 2018-2020 оны өрхийн хэрэглээнд үндэслэж, хэрэглээний бараа, үйлчилгээний жинг 3 оны дунджаар тооцож, 2020 оны суурь болгон ашиглаж эхэллээ.

ӨНЭЗС-ны эцэслэсэн үр дүнгээр тооцсон 2020 оны жинг 2015 оны жинтэй харьцуулахад хувцас, бөс бараа, согтууруулах ундаа, тамхи, амралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоол, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн жин 0.1-4.3 нэгж хувиар буурч, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэрэгсэл, шуудан, орон сууц, ус, цахилгаан, гэр ахуйн тавилга, бараа, боловсролын үйлчилгээ, бусад бараа, үйлчилгээний бүлгийн жин 0.3-3.6 нэгж хувиар өссөн.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд тусгах нэр төрөл, тоог шинэчлэн тогтоож, сагсан дах нэр төрөл 373-аас 410 болж, нэмэгдлээ. “Хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээний шинэ ангилал”-ын дагуу “Даатгал, санхүүгийн үйлчилгээ”-г тусгай бүлэг болгож, 12 бүлэг нь 13 болж нэмэгдсэн.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 13.2 хувь, өмнөх сараас 1.0 хувиар өссөн байна.

### ХҮСНЭГТ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2022 оны 12 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2022 XII 2021 XII	2022 XII 2022 XI
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>113.2</b>	<b>101.0</b>
Хүнсний бараа, ундаа, ус	25.1	115.4	101.9
Согтууруулах ундаа, тамхи	1.2	108.1	100.6
Хувцас, бөс бараа, гутал	12.3	118.5	101.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.3	115.4	100.6
Гэр ахуйн тавилга, бараа	5.4	114.7	100.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3	117.4	99.6
Тээвэр	16.3	106.2	100.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9	102.2	100.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9	110.0	100.7
Боловсролын үйлчилгээ	5.2	106.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9	115.1	100.4
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5	103.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.7	121.3	102.8

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 24.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 18.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 6.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



### 1.3.2 Судалгаа шинжилгээ

#### “Монгол Улсын ядуурлын шилжилт” судалгааны ажил

Ядуурлын шилжилт нь хүн амын дунд байнгын ядуу, ядуурлаас ангижирсан, ядууралд өртсөн, ядуурлаас ангид гэсэн дөрвөн төрлийн хэв шинж (ядуу-ядуу, ядуу-ядуу бус, ядуу бус-ядуу, ядуу бус-ядуу бус)-ийн өөрчлөлтөөр тодорхойлогдох бөгөөд судалгааны зорилго нь энэхүү шилжилтийг улсын түвшинд тооцоход чиглэсэн байв. Энэхүү судалгаанд Өрхийн нийгэм, эдийн засгийн 2014, 2018 оны судалгааны зэрэгцүүлсэн өгөгдлийг ашиглан синтетик-панел өгөгдөл үүсгэж ашигласан.

#### Судалгааны үр дүнгээс

Судалгааны үр дүнгээр 2014-2018 онд нийт хүн амын 7.3-18.6 хувь нь байнгын ядууралд байсан бол 6.9-18.2 хувь нь шинээр ядууралд өртсөн байна. Харин нийт хүн амын 0.4-6.2 хувь нь ядуурлаас ангижирсан байна. Байнгын ядууралд өртсөн өрхийн ерөнхий шинж чанарт өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй, 7 хүртэлх жилийн боловсролтой, гэрлэсэн ч батлуулаагүй, 4-ээс дээш ам бүлтэй зэрэг шинж чанарууд багтаж байна.

#### ХҮСНЭГТ 9. МОНГОЛ УЛСЫН ЯДУУРЛЫН ШИЛЖИЛТ, интервал үнэлгээ, загвар

	Доод	Дээд
Ядуу → ядуу	0.073	0.186
Ядуу бус → ядуу	0.069	0.182
Ядуу → ядуу бус	0.004	0.062
Ядуу бус → ядуу бус	0.684	0.741

#### Агаарын бохирдлын хөдөлмөрийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөөллийн судалгаа

Энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын хөдөлмөрийн нийлүүлэлтэд агаарын бохирдол хэрхэн нөлөөлж буйг судлахыг зорьсон. Ажиллах хүчний судалгаа (АХС)-ны болон агаарын бохирдлын 2015 оны 2 дугаар сараас 2017 оны 12 дугаар сар хүртэлх хугацааны өгөгдлийг ашиглан, 19-65 насны хүмүүсийг хамруулсан бөгөөд одоо сурч байгаа, гэрийн ажил эрхэлдэг, хүүхэд харж байгаа, татварт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй ирсдэг, сасах зооцооны хийлээ,

### Судалгааны үр дүнгээс

Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) болон нарийн ширхэгт тоосонцор (PM<sub>10</sub>)-ыг тайлбарлагч хувьсагчаар ашигласан бөгөөд агаарын бохирдлын богино хугацааны нөлөөллийг тодорхойлохын тулд тайлбарлагч хувьсагчийг нэг долоо хоногийн хоцрогдолтойгоор авсан. Агаарын бохирдол их байх нь ажил хийх болон хэр удаан ажиллах шийдвэрт нөлөөлдөг болохыг шинжилгээний үр дүн харууллаа. Тухайлбал, хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) 10 мкг/м<sup>3</sup>-ээр нэмэгдэхэд дараагийн долоо хоногийн ажиллах хүчний нийлүүлэлтийг 0.27 цаг буюу 16 минутаар бууруулахад хүргэдэг бол нарийн ширхэгт тоосонцор (PM<sub>10</sub>) 10 мкг/м<sup>3</sup> -ээр нэмэгдэхэд дараагийн долоо хоногийн ажлын цагийг 4.2 минутаар буурахад хүргэдэг байна.

### ХҮСНЭГТ 10. АГААРЫН БОХИРДЛЫН ХӨДӨЛМӨРИЙН НИЙЛҮҮЛЭЛТЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, threshold регрессийн загвар

Хувьсагчид	7 хоногт ажилласан цаг	
	PM <sub>10, t-1</sub>	SO <sub>2, t-1</sub>
PM <sub>10, t-1</sub>	-0.0068** (0.0034)	
SO <sub>2, t-1</sub>		-0.0300*** (0.0106)
Хувь хүний тогтмол нөлөөлөл (Individual FE)		Yes
Хугацааны тогтмол нөлөөлөл (Year FE)		Yes
Хугацааны тогтмол нөлөөлөл (Month FE)		Yes
Дүүргийн тогтмол нөлөөлөл (District FE)		Yes
Тогтмол хувьсагч	39.39** (2.025)	40.00** (2.292)
Ажиглалтын тоо	7.478	9.238

Standard errors in parentheses

\*\*\* p<0.01, \*\* p<0.05, \* p<0.1

### Эдийн засгийн бүсчилсэн хөгжил ба дотоод шилжих хөдөлгөөний хамаарлын шинжилгээ

Энэхүү шинжилгээгээр шилжилт хөдөлгөөний бүс нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэмжихийг зорьсон. Ингэхдээ аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны тооллого (ААНБТ) болон шилжих хөдөлгөөний мэдээллийг ашиглалаа.

### Судалгааны үр дүнгээс

Шилжигчид нь тухайн бүс нутгийн нэг хүнд ногдох орлогын түвшнээс шалтгаалан шилжин очих шийдвэр гаргах магадлалтай бөгөөд шилжин ирэгсэд нь тухайн бүс нутгийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, нэг ажилтанд ногдох орлого болон хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлж байна. Орон нутгийн хувьд нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого 10 хувиар нэмэгдэхэд хөдөлмөрийн насны шилжин ирэгчид 2.3 хувиар нэмэгдэх хандлагатай байна. Харин нийслэлийн хувьд нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого 10 хувиар нэмэгдэхэд хөдөлмөрийн насны шилжин ирэгчид 5.3 хувиар өсөхөөр байна. Инновац хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжийн тоо 10 хувиар нэмэгдэхэд хөдөлмөрийн насны шилжин ирэгчдийн тоо 0.02 хувиар нэмэгдэхээр байна.

### ХҮСНЭГТ 11. РЕГРЕССИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)
2020 он	-0.801***	-0.725***	1.076***	0.980***	0.035	0.032
<del>Хявгийн бүс</del>	<del>0.428*</del>	<del>0.428*</del>	<del>1.076***</del>	<del>0.980***</del>	<del>0.035</del>	<del>0.032</del>
Төвийн бүс		0.604*		0.367		-0.004
Зүүн бүс		0.150		0.500		-0.019
Log(Нэг ажилтанд ногдох орлого)	0.364**	0.234*				
Log (Хөдөлмөрийн насны шилжин ирэгчид)			0.841***	0.678*	0.052**	0.047*
Тогтмол	2.998**	3.906***	4.171**	5.022**	-0.136	-0.088
IV			Yes	Yes	Yes	Yes
r <sup>2</sup>	0.39	0.52	0.31	0.39	0.11	0.21
N	42	42	42	42	42	42

Тайлбар: \*\*\*,\*\*,\* тус бүр нь 1%, 5%, 10%-ийн түвшинд ач холбогдолтой. (1)-(6) хүртэлх багана нь регрессийн 6 өөр загварыг илтгэх ба сүүлийн 4 загвар нь IV загвар болно. Энэхүү шинжилгээнд баруун бүс болон 2015 оныг суурь болгон бүс нутаг болон оны тогтмол нөлөөллийг дамми хувьсагч болгон үнэлсэн.

### Их, дээд сургуулиудыг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлснээр орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө

Монгол Улсын Засгийн газраас орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах тогтоол гаргасан.

Шинжилгээгээр их сургуулиудын хотхон байгуулснаар тухайн орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг харуулахыг зорьсон. Судалгаанд төрийн өмчит их сургуулийг цогцолбор хотхонтой болгох зорилготой сургалт-эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор төслийн холбогдох мэдээллийг ашиглав.

#### Судалгааны үр дүнгээс

Их сургуулиудын хотхоны нөлөөгөөр үүсэх шилжих хөдөлгөөний шууд болон шууд бус нөлөөгөөр сургалт, эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах 4 байршилд нийтдээ 75.1 мянган хүн ам шилжихээр, 17.1 мянган ажлын байр бий болох хандлагатай байна.

Эдийн засгийн хувьд ажиллагчдын тооны нөлөөгөөр Дархан-Уул аймгийн ДНБ 1.0%, Орхон аймгийнх 0.5%, Өмнөговь аймгийнх 0.8%, Төв аймгийнх 3.8%-иар тус тус өсөхөөр байгаа хэдий ч хүн амын гарах урсгалаас шалтгаалж Улаанбаатар хотын ДНБ 2.2%-иар, Монгол Улсын эдийн засаг 1.3%-иар буурах хандлага харагдаж байна.

**ХҮСНЭГТ 12. ТООЦООНЫ ҮР ДҮН, байршлаар**

	Дархан	Эрдэнэт	Өмнөговь	Хөшгийн хөндий	Улаанбаатар
<b>Компанийн тоо</b>					
Шууд болон шууд бус нөлөөллөөр шилжих хүн амын тоо	+6 959	+6 959	+5 565	+55 665	-75 148
ААНБ-ын тооны өөрчлөлт	+298	+321	+330	+2 199	-4 945
<b>Шууд болон шууд бусаар бий болох ажлын байрны өөрчлөлт</b>					
Шууд ажлын байрны өөрчлөлт	+417	+417	+333	+3333	-4500
Шууд бус ажлын байрны өөрчлөлт	+1 192	+1284	+1 320	+8 796	-18 296
<b>Нийт</b>	<b>+1 609</b>	<b>+1 701</b>	<b>+1 653</b>	<b>+12 129</b>	<b>-22 796</b>

**Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, төрийн бодлого, шийдвэрт ашиглах нь: Кейс шинжилгээ**

Зорилтот бүлгийг тодорхойлохдоо Нийгмийн халамжийн мэдээллийн сан (НХМС), Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС), Нийгмийн даатгалын мэдээллийн сан (НДМС), Авто тээврийн мэдээллийн сан (АТМС), Мал тооллогын мэдээллийн сан (МТМС)-г ашигласан бөгөөд нийт 32392 өрхийг зорилтот бүлгээр сонгосон.

Цахилгааны үнийг 20 хувиар нэмэгдүүлэхэд эдгээр 32392 өрхийн цахилгааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 2.6 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай болохыг тооцсон.

**"Монгол Улсын эдийн засгийн өсөлт ба хүн амын өсөлтийн хамаарлыг ARDL загвараар үнэлэх нь" судалгааны ажил**

Уг судалгааны ажлаар хүн амын өсөлт болон эдийн засгийн өсөлтийн хамаарлыг тодорхойлох ARDL үнэлгээг хийх зорилтыг дэвшүүлж, 1981-2020 он хүртэлх 40 жилийн хүн амын өсөлт болон эдийн засгийн өсөлтийн тоо мэдээллийг ашиглав.

**Судалгааны үр дүнгээс**

Богино хугацаанд Монгол Улсын хүн амын өсөлтийг хүн амын өсөлтийн 1 хугацааны хоцролт эерэг хамааралтай буюу 0.56 хувиар нэмэгдүүлж, харин хүн амын өсөлтийн 2 хугацааны хоцролт сөрөг хамааралтай буюу 0.54 хувиар бууруулж байна.

Богино хугацаанд Монгол Улсын ДНБ-ий өсөлтийг хүн амын өсөлтийн хоцролт эерэг хамааралтай буюу 3.43 хувиар, ДНБ-ий өсөлтийн 1 хугацааны хоцролт мөн эерэг хамааралтай буюу 0.63 хувиар нэмэгдүүлж байна.

**ХҮСНЭГТ 13. УРТ БА БОГИНО ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Урт хугацаанд		Загвар 1		Загвар 2	
Хувьсагчид					
	Тогтмол тоо	0.571***			
		(0.110)			
	lnPOP			2.943***	
				(0.615)	
	lnGDP	0.326***			
		(0.014)			
	ln POP <sub>t-1</sub>	-0.075***			
		(0.014)			
Богино хугацаанд		Загвар 1		Загвар 2	
Хувьсагчид					
	$\Delta \ln \text{POP}_{t-1}$	0.560***			
		(0.132)			
	$\Delta \ln \text{POP}_{t-2}$	-0.541***			
		(0.117)			
	$\Delta \ln \text{POP}_t$			3.429**	
				(1.62)	
	$\Delta \ln \text{GDP}_{t-1}$			0.625***	
				(0.155)	
	ECT	-0.075***			
		(0.013)			
	Prob > F статистик	0.000000***		0.000036***	
	R <sup>2</sup> (үнэлэгдсэн утгыг тайлбарлах чадвар)	0.771246		0.531845	

**“Монгол Улсын ядуурлын зураглал” судалгааны ажил**

Олон улсад өргөн хэрэглэгддэг “Жижиг нутаг дэвсгэрийн тооцоолол” аргачлал ашиглан ядуурлыг сумын түвшинд тооцоолж гаргах зорилготой. Уг судалгаанд хүн амын тооллого болон Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны мэдээллийг ашигладаг. Монгол Улсын хувьд 2010 онд анх удаа Үндэсний Статистикийн Хороо Дэлхийн банкны зөвлөхийн дэмжлэгтэйгээр уг судалгааг гүйцэтгэж байсан бөгөөд энэ удаа 2020 оны хүн ам, орон сууцны тооллого, ӨНЭЗС зэргийн өгөгдлийг ашиглан мөнгөн дүнгээр хэмжигдэх ядуурлыг сумын түвшинд тооцохоор ажиллаж байна.

**“Сурагчдын гэр, сургуулийн байршлыг тодорхойлох, сургуулийн зай, замын түгжрэлийн хамаарлыг гаргах” судалгааны ажил**

УБ хотын түгжрэлд аль зам, чиглэл, уулзварт хэчнээн давхцал байгаа талаарх нарийн судалгаа хийгдээгүй байна. Энэ судалгааны зорилго “гэр – сургууль, сургууль – гэр, гэр – ажил, ажил – гэр, гэр – цэцэрлэг, цэцэрлэг – гэр” гэсэн маршрутыг нарийн судалж нөлөөллийг илрүүлэх, тооцох орон зайн дүн шинжилгээ хийх байв.

Улаанбаатар хотын зам, сурагчдын сургуулийн зайнаас хамаарсан хөдөлгөөний ачааллыг тооцохдоо Боловсролын мэдээллийн сангийн Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын 2021-2022 оны хичээлийн жилийн мэдээлэл, ХАӨМС-ийн 2022 оны өрхийн байршил болон сурагчдын мэдээлэл, Open Street шар нээлтэй агаарийн Улаанбаатар хотын зам замын мэдээллийг ашигласан.



## Цар тахал ба ЕБС-ийн сургалтын чанарын хамаарлыг гаргах судалгаа

Ковид-19 цар тахал ЕБС-ийн сургалтын чанарт хэрхэн нөлөөлснийг судлах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийсэн. Судалгаанд Боловсролын үнэлгээний төвийн 2019-2022 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны мэдээллийг ашиглав.

### Судалгааны үр дүнгээс

Олон үзүүлэлтийн бүлгийн нэмэлт түүвэр судалгааны үр дүнгээр Монгол Улсын нийт сурагчдын 30 хувь нь цар тахлаас шалтгаалан сургалтын чанар муудсан гэж үзсэн байна. Сурагчдын сургалтын чанар тодорхой үзүүлэлтийн хувьд ялгаатай байгаа эсэхийг шалгаж үзэхэд бүх шатанд адил үр дүн гарсан. Тухайлбал 1-12 анги, улсын болон хувийн сургуульд суралцдаг эсэх, гэртээ интернэттэй эсэхээс үл хамааран сургалтын чанар нийтээр муудсан байна. Харин ЭЕШ-ын мэдээлэлд үндэслэн сурагчдын сургалтын чанар цар тахлын нөлөөг үнэлэхэд цар тахлаас шалтгаалан сурагчдын сурлагын амжилт 5 хувиар буурсан байна. Цар тахлын дараах нөлөө цар тахлын үеийнхээс ихэссэн бөгөөд сурлагын амжилт 8 хувиар буурсан байна.

ЗУРАГ 21. ЭЕШ-Д ХАМРАГДАГЧИД БОЛОН ЕБС ТӨГСӨГЧИД, тоо, харьцаа




### Монгол Улс дахь нийгмийн шилжилт хөдөлгөөний шинжилгээ:

Монгол Улс дахь боловсрол, хөдөлмөр эрхлэлт, өрхийн баялаг гэх мэт нийгмийн гол үзүүлэлтийн хувьд үе доторх шилжих хөдөлгөөн хэрхэн явагдаж байгааг судлах мөн нийгмийн гол үзүүлэлтүүдээр хэмжсэн үе хоорондын шилжих хөдөлгөөнийг тодорхойлоход судалгааны зорилго оршиж байв. Судалгаанд Хүн ам, орон сууцны 2010, 2020 оны тооллогын мэдээллийг ашиглалаа.

### Судалгааны үр дүнгээс

2010 онд эцэг эхтэйгээ хамт амьдарч байсан 15 ба түүнээс дээш настай хүмүүсийн 39.8 хувьд үе хоорондын боловсролын үнэмлэхүй өгсөлт явагдсан бол 60.2 хувьд явагдаагүй байна. Үе хоорондын хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд үнэмлэхүй өгсөлт явагдсан 23.5 хувь, явагдаагүй 67.0 хувь, уруудсан 9.5 хувь байна. Мөн нийслэлд төрсөн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн өгсөх шилжилт хийх магадлал бүх насныхны хувьд хамгийн өндөр бол хөдөөд төрсөн хүмүүсийн өгсөх магадлал хамгийн бага байна.

**ЗУРАГ 22. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЕ ДОТОРХ ҮНЭМЛЭХҮЙ ӨГСӨЛТ, 2010-2020 он, төрсөн байршлаар**



**Аж ахуйн нэгжийн гүйцэтгэл, инновацын хамаарлын шинжилгээ:**

Инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлөхийг шинжлэхийг зорьсон. Ингэхдээ өгөгдлийн бүтэц нь тухайн цаг үе дэх хөндлөн огтлолын өгөгдөл тул инновац болон бусад удирдах хувьсагчдыг тайлбарлагч хувьсагчаар сонгож, ААН-ийн борлуулалтын орлогын логарифм утгыг тайлбарлагдагч хувьсагчаар сонгож эдгээрийн хоорондын хамаарлыг бичил, жижиг, дунд, том аж ахуйн нэгжийн хувьд энгийн шугаман регрессийн загвараар үнэллээ.

Судалгаанд “Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого”-ын өгөгдлийг ашигласан. Аж ахуйн нэгжийг ангилахдаа жилийн борлуулалтын орлого нь 300.0 сая төгрөг хүртэлх бол бичил, 300.0-1.0 тэрбум төгрөг бол жижиг, 1.0-2.5 тэрбум төгрөг бол дунд, 2,5 тэрбумаас дээш төгрөгийн орлоготой бол том гэж үзлээ.

**Судалгааны үр дүнгээс**

Инновацын үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь ямар ч хэмжээний ААН-ийн гүйцэтгэлд эерэг нөлөөтэй байгаа нь шинжилгээгээр дараах байдлаар батлагдсан.

Бичил, жижиг ААН нь инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бусад хүчин зүйл тогтмол байхад орлого нь 35 хувиар өсөхөөр байна. Харин жижиг ААН-ийн захирал эрэгтэй бол эмэгтэй захиралтай байхтай харьцуулахад орлогыг 6.0 хувиар өсгөхөөр байна. Мөн ажиллагчдын тоо нэгжээр өсөхөд орлого 6.2 хувиар өсөхөөр байна.

Дунд хэмжээний ААН нь инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд инновацын үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй ААН-тэй харьцуулахад орлого нь 3.2 хувиар өсөхөөр байна.

Харин том хэмжээний ААН нь инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд инновацын үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй ААН-тэй харьцуулахад орлого нь 20.8 хувиар өсөхөөр байна. Мөн том ААН гадаадын хөрөнгө оруулалттай, экспортод бүтээгдэхүүн гаргадаг бол орлого нь 29.0 хувиар тус өсөхөөр байна.

### ХҮСНЭГТ 14. ЗАГВАРЫН ҮР ДҮН

	Бичил, жижиг ААН		Дунд хэмжээний ААН		Томоохон ААН	
	Log (орлого)	t	Log (орлого)	t	Log (орлого)	t
Нөхөрлөл	-0.400***	(-7.57)	0.0176	(0.25)	-0.448	(-0.97)
Хоршоо	-1.313***	(-25.27)	-0.0705	(-0.85)	-0.0879	(-0.21)
ТӨҮГ/ОНӨҮГ	-0.0390	(-0.33)	0.159***	(3.34)	-0.295*	(-2.04)
Бусад	0.0967	(0.83)	0.133	(1.62)	-0.0232	(-0.08)
Уул уурхай	0.0189	(0.18)	0.0950*	(2.01)	0.560**	(2.71)
Боловсруулах	0.0676	(1.35)	0.102**	(2.73)	0.335	(1.69)
Барилга, дэд бүтэц	0.841***	(16.43)	0.103**	(2.92)	0.227	(1.17)
Бөөний худалдаа	0.471***	(9.81)	0.0843*	(2.37)	0.415*	(2.13)
Жижиглэнгийн худалдаа	0.652***	(14.43)	0.0817*	(2.32)	0.406*	(2.08)
Тээврийн хэрэгслийн засвар, худалдаа	0.468***	(6.21)	0.0709	(1.43)	0.211	(0.90)
Боловсрол	-0.337***	(-3.91)	-0.00948	(-0.13)	-0.0977	(-0.34)
Зочид буудал, зоогийн газар	0.169**	(2.64)	0.133**	(3.01)	-0.142	(-0.60)
Санхүү, даатгал	0.203**	(3.19)	0.0410	(0.91)	0.497*	(2.36)
Тээвэр, агуулах	0.535***	(8.03)	0.0964*	(2.39)	0.0534	(0.26)
Удирдлага	0.0787	(1.27)	0.0782	(1.82)	0.0896	(0.40)
Урлаг, үзвэр	-0.273	(-1.37)	-0.0404	(-0.22)	0.252	(0.45)
Үл хөдлөх хөрөнгө	0.428***	(5.85)	0.106*	(2.26)	0.207	(0.91)
Шинжлэх ухаан	-0.184***	(-3.55)	0.0617	(1.43)	0.153	(0.69)
Эрүүл мэнд	0.0976	(1.61)	0.0399	(0.83)	-0.193	(-0.78)
Бусад	-0.0674	(-1.09)	0.112*	(2.34)	0.188	(0.85)
Ажиллагчдын тоо 2018-2021 онд	0.0623***	(47.70)	0.000146*	(2.44)	0.00204***	(26.77)
инновац хэрэгжүүлсэн	0.358***	(17.38)	0.0322**	(3.18)	0.208***	(5.59)
Эрэгтэй захиралтай	0.0608**	(3.22)	-0.00700	(-0.65)	0.0693	(1.66)
Экспортын бүтээгдэхүүн гаргадаг	0.0715	(1.36)	0.0310	(1.32)	0.290***	(4.43)
Гадаадын хөрөнгө оруулалттай	-0.0520	(-0.61)	-0.0186	(-0.62)	0.291***	(3.84)
Constant	10.31***	(234.61)	14.12***	(407.15)	15.19***	(78.33)
Ажиглалтын тоо	33 139		2 741		2 449	

t statistics in parentheses

\* p < 0.05, \*\* p < 0.01, \*\*\* p < 0.001

#### Бусад тайлан, танилцуулга:

- "ТХЗ: 17.13.1 макро эдийн засгийн хяналтын үзүүлэлтүүд" сэдвийн хүрээнд бага болон дундаж орлоготой орнууд, Зүүн Ази, Номхон Далайн орнууд, Европ, Төв Ази, Өмнөд Азийн орнууд, ОХУ, БНХАУ болон Монгол Улсын эдийн засгийн 2015-2020 оны гол үзүүлэлтүүдийг ашиглан харьцуулсан танилцуулга бэлтгэлээ.
- "Эдийн засгийн аюулгүй байдал" танилцуулгыг бэлтгэж, УИХ-ын байнгын хороод, Эдийн засгийн аюулгүй байдлын зөвлөл (ЭЗАБЗ)-д хэвлэмэл хэлбэрээр хүргүүлсэн.


## 1.4 СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ ЭХ ҮҮСВЭР

ДНБ-ийг сарын давтамжтайгаар шинээр туршилтаар тооцох ажлыг эхэлж, тооцооны үр дүнг 6 дугаар сараас эхлэн зөвхөн бодлого боловсруулагчид буюу Сангийн яам, Монголбанк, Эдийн засгийн хөгжлийн яам, ОУВС, АХБ зэрэг байгууллагын албан хэрэгцээнд ашиглахаар тархааж байна.

ОУВС-гаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд сарын ДНБ-ийг тооцох боломжийг тус байгууллагын зөвлөх үйлчилгээ авч үнэлсэн. Уг үнэлгээнд Монгол Улсын хувьд ДНБ-ий үзүүлэлтийг сараар тооцоход ДНБ-ий гүйцэтгэлийн 65 хувь нь үндсэн мэдээллийн үзүүлэлтээр, 29 хувийг холбогдох бусад мэдээлэл, тооцооны аргыг ашиглан тооцох боломжтой, үлдсэн 6 хувийн мэдээллийг гаргах боломжгүй гэж үнэлсэн.


ДНБ-ийг сараар тооцохдоо улирлын ДНБ-ийг тооцох арга зүйг баримталж байна. Салбарын сарын тооцоолд НӨАТ-ын мэдээллийг ашиглаж байна. Цаашид НӨАТУС-ийн мэдээллийг ашиглах нь богино давтамжтай мэдээллийг нэмэгдүүлэх ач холбогдолтой бөгөөд ДНБ-ий тооцооны мэдээллийн чанар, бодит байдалд эергээр нөлөөлнө. Сарын ДНБ-ий туршилт тооцооны үр дүнг зурагт харуулав.

ЗУРАГ 23. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, сараар, хувиар



ҮСХ нь бүтээгдэхүүний үнийн өсөлт, инфляцын талаарх мэдээллээр төрийн засгийн бодлого боловсруулагчдыг шуурхай хангах үүднээс хүнсний гол барааны 7 хоногийн үнийн мэдээллийг 100 орчим бараа, үйлчилгээгээр өргөтгөж, үүнд үндэслэн сарын инфляцын төсөөлөл тооцоог хийж, үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх гол нэрийн барааны үнэ, танилцуулгын хамт бэлтгэж, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.

**ЗУРАГ 24. 7 ХОНОГИЙН МЭДЭЭНД ҮНДЭСЛЭСЭН ИНФЛЯЦЫН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО**




Цахим төлбөрийн баримтын мэдээлэлд үндэслэн 7 хоногийн дундаж үнийг туршилтаар тооцож, дашбоард байгуулах ажилд Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (ГТСМТТ)-тэй хамтран ажиллаж, үүний үр дүнд цахим төлбөрийн баримтын мэдээллийн сангаас бараа, бүтээгдэхүүнийг хиймэл оюун ухаан, машин сургах аргаар таниулж, үнийн мэдээллийг 6 томоохон супермаркетаар гаргуулж, ҮСХ-ноос цуглуулсан мэдээлэлтэй харьцуулан мэдээллийн зөрүү, шалтгааныг тогтоох ажлуудыг хийж, цаашид барааны код, ангиллыг сайжруулж, үнийн мэдээнд шууд ашиглах боломжийг туршиж байна.

Цахим төлбөрийн баримтын сан, 7 хоногийн үнийн мэдээлэл гаргах дашбоардыг дараах байдлаар харуулав.

**ЗУРАГ 25. СҮҮНИЙ ҮНЭ, төгрөг, томоохон супермаркетаар, өдрөөр**

	Дэлгүүр 1	Дэлгүүр 2	Дэлгүүр 3	Дэлгүүр 4	Дэлгүүр 5	Дэлгүүр 6	Дэлгүүр 7
2/28/2023	1796.77	960.89	2987.75	1590.43	3027.94	2910.73	2122.33
3/1/2023	1805.64	960.16	2853.99	1588.24	2982.30	2626.85	2088.13
3/2/2023	1831.8	960.83	2845.76	1591.21	3096.98	2707.17	2148.23
3/3/2023	1805.19	959.34	2930.36	1578.51	-	2687.85	2148.03
3/4/2023	1809.96	959.18	3002.86	1585.98	-	2786.35	2101.90
3/5/2023	1789.66	960.21	3005.82	1589.83	4187.00	2834.25	2120.64
3/6/2023	1794.69	960.59	3137.30	1595.82	-	2840.53	2059.17
3/7/2023	1835.63	960.1	2999.07	1588.96	-	2835.89	2064.03
3/8/2023	1824.51	959.93	3060.00	1584.77	-	2487.67	2158.1
3/9/2023	1806.25	959.73	2951.13	1603.42	-	2616.32	2200.0



## 1.5 МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

ҮСХ нь Статистикийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг сар бүр, ДНБ-ий тооцоог улирал бүр, статистикийн жилийн эмхэтгэл, салбарын танилцуулгыг жил бүр, тооллого, судалгааны үр дүн, хэтийн тооцоо, судалгаа, шинжилгээний ажлыг тухай бүр хэрэглэгчдэд хүргэж ажиллалаа.

Статистикийн байгууллагын мэдээлэл тархаах ажлын хүрээнд “Статистикийн байгууллагын мэдээлэл тархаалтын журам”, “Статистикийн бүтээгдэхүүн бэлтгэх заавар”-ыг батлан мөрдүүлж, албан ёсны статистикийн мэдээ, тооллого судалгааны дүнг 2022 онд тархаах хуваарийг батлан хэрэгжүүлэв.

ҮСХ нь Статистикийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний дотор анхдагч мэдээллийн чанарыг хангаж, чанартай, бодитой мэдээллээр бүх түвшний хэрэглэгчдийг ижил тэгш, шуурхай хангахад анхаарч байна. Үүнд: Статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг өргөн ашигласнаар мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, хэрэглэгчид статистикийн мэдээллийг орон зайнаас үл хамааран цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлсээр байна. Үүний үр дүнд Дэлхийн банк (ДБ)-наас улс орнуудын статистикийн байгууллагын чадавхыг үнэлдэг үнэлгээний гурван үндсэн үзүүлэлтийн нэг болох мэдээллийн давтамж, шуурхай байдлын үнэлгээгээр 2018 онд 83.3 оноо авч байсан бол 2020 оны үнэлгээгээр 86.7 оноо авсан. Мөн Open Data Watch олон улсын байгууллагаас дэлхийн 192 орны статистикийн байгууллагуудын мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлыг үнэлсэн 2022 оны үнэлгээгээр Монгол Улс дэлхийд 8 дугаар байрт орсон амжилт гаргалаа.

Мөн ҮСХ нь Олон улсын валютын сан (ОУВС)-гийн Мэдээлэл тархаалтын тусгай стандарт (SDDS)-ыг хэрэгжүүлдэг.

### 1.5.1 Хэвлэмэл бүтээгдэхүүн

ҮСХ-ноос дараах бүтээгдэхүүнийг хэвлэмэл хэлбэрээр, хэрэглэгчид, олон нийтэд тархаалаа:

- “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал” сар бүрийн танилцуулга
- Статистикийн эмхэтгэл – 2021
- Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үр дүн – 2021
- “Монгол Улсын шинэ үндсэн хууль – 30 жил” зурагт эмхэтгэл



### 1.5.2 Цахим бүтээгдэхүүн

Статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг өргөн ашиглаж, цахим мэдээллийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтой хэлбэрээр нээлттэй байлгахад анхаарч цахим бүтээгдэхүүнийг мэдээлэл тархаалтад түлхүү ашиглаж байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))-д ҮСХ-ноос гарч буй цахим бүтээгдэхүүн, өгөгдөл, мэдээлэл үнэ төлбөргүй байршдаг бөгөөд статистикийн жилийн эмхэтгэл, сарын бюллетень, сарын мэдээний танилцуулга,

Үндсэн хуулийн 30 жилийн ойн зурагт эмхэтгэл, ААНТ-ын болон ӨНЭЗС, АХС-ны үр дүн, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, үнэ зэрэг салбаруудын 35 танилцуулга, судалгааны үр дүнг байршуулж, хэрэглэгчдэд тархаалаа.

2022 онд 56 удаагийн видео контент, 420 ширхэг зурагт хуудас бэлтгэж, хэрэглэгчдэд “Үндэсний Статистикийн Хороо” фэйсбүүк хуудас, Viber, Telegram, LinkedIn, Twitter, Youtube зэрэг сувгуудаар тархаасан.

Аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй, худалдаа, тээвэр, зочид буудал, зоогийн газар, банк, санхүү, төсөв, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, гол нэрийн зарим барааны үнэ, хэрэглээний бараа, үйлчилгээ, үйлдвэрлэгчийн үнийн мэдээг 7, 14 хоног, сар, улирал, жилээр нэгтгэн боловсруулж, нэгтгэл болон индексийн тооцоог Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn)) цахим хуудсанд эдийн засгийн 26 салбарын мэдээллээр нийт 571 үзүүлэлтэд баяжилт хийж, хэрэглэгчдэд тархаалаа.

### 1.5.3 Сургалт, мэдээллийн үйлчилгээ


Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийг сайжруулах зорилгоор 3 удаа хэлэлцүүлэг, 12 удаа сургалт зохион байгууллаа:

- “ҮСХ-ноос сэтгүүлчидтэй уулзах уулзалт” хэлэлцүүлгийг зохион байгуулж, 40 гаруй сэтгүүлч оролцсон.
- “Статистикийн арга, аргазүй” цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, 400 гаруй хүнийг хамруулсан.
- Монголбанктай хамтран “ДНБ болон ХҮИ-ийн статистик боловсруулах аргачлалын танилцуулга” хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Статистикийн мэдээллийг хэрхэн олж авах, ашиглах талаарх сургалтуудад БХБЯ (2 удаа), Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар (2 удаа), Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ), Сангийн яам, Төрийн банк, Хөгжлийн банк, Соёлын яам, Тээврийн цагдаагийн алба, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Жендэрийн үндэсний хорооны албан хаагчид хамрагдсан.

Түүнчлэн статистикийн алба байгуулагдсан өдрийг тохиолдуулан нийслэл, аймгийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн сурагч, оюутнуудад уламжлал ёсоор “Статистикийн боловсрол” сургалтыг зохион байгууллаа.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газруудын албан хаагчдад “Статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалт” сургалтыг жил бүр зохион байгуулж байна.

## ХОЁР. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА



## ХАМТЫН АЖИЛЛАГАА



United Nations  
Statistics Division



ASIAN DEVELOPMENT BANK



Australian  
Bureau of  
Statistics



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарская организация развития




통계청  
Statistics Korea

PARIS21





## ТӨРИЙН ИХ ӨГӨГДӨЛ ТӨСӨЛ



ASIAN DEVELOPMENT BANK



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

Төрийн их өгөгдөл төслийн санхүүжилт батлагдлаа.

## ЧАНАРЫН ЖУРАМ



**ХАӨМС-ийн үйл ажиллагаанд баримтлах журам**

**Статистикийн мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам**

**Статистикийн бизнес регистрийг хөтлөх, ашиглах журам**

**Арга зүйн байнгын зөвлөлийн ажиллах журам**


**ӨНЭЭС, АХС-ны мэдээлэл цуглуулах багийн ажиллах журам**

Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах, үнэлэх зорилгоор 5 журмыг батлав.

## 2.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Статистикийн тухай хуульд заасан ҮСХ-ны бүрэн эрхийг хэрэгжүүлэх, албан ёсны статистикийн шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээлэл, өгөгдлийн байнга өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангах зорилготой 8 газар, 16 хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 26. ҮСХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## 2.2. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ШИНЭЧЛЭЛ

### 2.2.1 Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар /СҮАЕЗ/

Албан ёсны статистикийн шинэчлэлийн стандарт - Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (СҮАЕЗ)-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн Дансны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үндэсний Статистикийн системийг бэхжүүлэх нь” төслийг эхлүүлээ.

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (СҮАЕЗ)-ын дагуу статистикийн үйлдвэрлэлийн үе шат бүрд шаардлагатай ур чадварын өнөөгийн түвшин тодорхойлох, статистикийн сургалтын хүрээ, зураглалыг боловсруулах зорилгоор ҮСХ-ны ахлах статистикч, статистикч (56 оролцогч) нарыг статистикийн мэдлэг, техникийн ур чадварын түвшин тодорхойлох судалгааг явуулж, судалгааны үр дүнд суурилан “СҮАЕЗ-ын дагуу тодорхойлсон статистикийн сургалтын зураглал”-ыг боловсруулсан. Мөн дээрх төслийн хүрээнд үндэсний статистикийн системийн үйл ажиллагаанд олон улсын цогц үнэлгээг 2023 онд хийхтэй холбогдсон бэлтгэл ажлуудыг хийж байна.

## 2.2.2 Мэдээллийн чанар

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (СҮАЕЗ)-ын хэрэгжилтийн хүрээнд "Статистикийн чанарын удирдлагын хүрээ, хэм хэмжээ" баримт бичгийг шинэчлэн баталсан.

Мөн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр онцгой анхаарч ӨНЭЗС, АХС-ны мэдээлэл цуглуулах багийн ажиллах журам, Статистикийн өгөгдөл, мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам, Арга зүйн байнгын зөвлөлийн ажиллах журам, СБР-ийг хөтлөх, ашиглах журам, ХАӨМС-гийн үйл ажиллагаанд баримтлах журам гэсэн 5 багц журам болон статистикийн мэдээний уялдааг хангах үзүүлэлтийн жагсаалтыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэллээ.

## 2.2.3 Статистикийн хууль эрх зүйн шинэчлэл

Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад ПАРИС21 байгууллагын санхүүжилтээр зөвлөх үйлчилгээ авч хамтран ажилласан. Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, аймаг, нийслэл, дүүргийн Статистикийн хэлтэс, 62 сумын төрийн сангийн төлөөлөгч, нийт 100 албан тушаалтныг оролцуулсан уулзалтыг зохион байгууллаа.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 814 хууль, 800 тогтоол, олон улсын 246 гэрээ, конвенцыг хамруулан тандан судалгаа хийж, тандан судалгааны тайлан, хуулийн төсөл боловсруулах үзэл баримтлалын болон хуулийн бичвэрийн эхний төслүүд бэлэн болсон.

## 2.2.4 Цахим шилжилт

Программ хангамж шинээр боловсруулах, статистикийн мэдээ, тайлан боловсруулалтын хүрээнд статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэгдсэн систем (SPS)-д сар, улирал, жилийн 40 мэдээг шилжүүлсэн. Одоогийн байдлаар 20 мэдээ бүрэн нэвтэрсэн, мэдээ авахад бэлэн болсон 10; нэмэлт хөгжүүлэлт шаардлагатай 10 мэдээ байна. Мөн системд мета дата үүсгэх сургалтыг салбарын хэмжээнд хийж, 506 мэдээ, 37 судалгааны мета өгөгдөл үүсгэж, ангилал, кодын санг баяжууллаа.

Зөөврийн хөдөлгөөнт төхөөрөмж буюу таблетыг бүх төрлийн тооллого, судалгааны мэдээлэл цуглуулалтад өргөн ашиглаж байна. Тухайлбал, ХАА-н улсын тооллогод 380 ширхэг таблетыг бэлтгэн, ХАА-н тооллогын программ, тухайн бүсийн газрын зураг болон бусад шаардлагатай программыг суулган ашигласан. Тооллого судалгааны мэдээлэл цуглуулалтад таблет ашигласнаар цаасны болон шивэлтийн зардлыг багасгаж, мэдээлэл цуглуулах, боловсруулахад зарцуулах хугацааг хэмнэхээс гадна мэдээллийг газар дээрээс шууд дамжуулах боломжтой. мэдээлэл цуглуулалтын ажилд хяналт тавих, цуглуулсан мэдээлэл алдаагүй бүрэн байх зэрэг олон боломжийг олгодог.

ҮСХ нь 2021 оноос Microsoft 365 оффисын багц программын платформыг нэвтрүүлсэн бөгөөд энэхүү платформыг ашиглан өдөр тутмын үйл ажиллагааг цахимжуулж байна. Microsoft Power Automate программыг ашиглан байгууллагын албан бичиг, тушаал төсөл болон сарын мэдээний хяналтыг цахимжуулснаар албан хаагчдын ажлын бүтээмж нэмэгдэж, цаасны хэрэглээг эрс багасгаж, байнга давтагддаг үйл ажиллагааг хурдасгасан.

## ЗУРАГ 27. ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ

The image displays a Microsoft 365 dashboard with six groups and a detailed view of the 'Албан бичиг' group's calendar.

**Groups Overview:**

- Албан бичиг:** Албан бичиг-527, А-Тушаал-197, Б-Тушаал-290
- Даргын зөвлөл Group:** Даргын зөвлөлөөр хянагдсан-10
- Арга зүйн байнгын зөвлөл Group:** Арга зүйн байнгын зөвлөлөөр хянагдав буй-1
- Цахим архив Group:** Дүрэм журмы-181, Архивлан-149, Мөхөт-475
- БГХХ - Бодлого, гадаад харилцааны хэлтэс Group:** Гадаад сургалтад нэр дэвшүүлэх-77
- МЭДЭЭ ХЯНАЛТ Group:** Мэдээ хяналт-441

**Албан бичиг Group Calendar View:**

Хүндэтгэл	Төсөл	Хэлтсийн дарга	Газрын дарга	ТТ-ын дарга	Дэд дарга	Дарга	Бичигч
Мобилийн ХХХ-д	Хийсэн	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/17 12:23:51	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/17 12:23:51	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/17 12:23:51	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/17 14:22:31	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/17 14:26:09	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/17 14:26:13
ТҮНДЭСНИЙ ДАТА ТӨС-Д	Хийсэн	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/21 09:28:43	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/21 09:34:33	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/21 09:34:33	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/21 09:34:33	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/21 10:29:08	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/11/21 10:29:08
"Мобилийн" ХХХ-д	Хийсэн	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:05:15	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:15:08	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:15:08	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:21:38	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:21:38	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:21:38
ТҮНДЭСНИЙ ДАТА ТӨС-Д	Хийсэн	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 11:47:52	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 11:47:52	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 11:47:52	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:58:23	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:58:23	Хийсэн Энх-Баярлан бүтээгдээгүй Тэмдэгт Эхлэсэн 2022/8/21 14:58:23

## 2.2.5 Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах “Төрийн их өгөгдөл” төсөл

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бодлого, түүний үр нөлөөг оновчтой тодорхойлох, төсвийн зардлыг хэмнэх, мэдээллийн уялдааг хангах, нэгдсэн стандартыг бий болгох, мэдээлэгчийн ачааллыг бууруулах Төрийн өгөгдлийн нэгдсэн сан байгуулах төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа. Үүний үр дүнд АХБ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 9 сарын 19-ний өдөр байгуулж, тус банк 2022 оны 12 сарын 9-ний өдөр уг төслийг хэрэгжүүлэх техникийн туслалцааг баталсан.

### Төслийн зорилго

Төслийн үр дүнд нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, төрийн секторын үр ашгийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд илүү сайн хүргэх боломжийг бүрдүүлэх мэдээллийн санг хөгжүүлж, удирдах суурь бий болгох зорилготой ба тогтвортой хөгжлийн зорилгын дараах зорилтуудтай уялдана.



### Төслийн зорилт

Нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, төрийн секторын үр ашгийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд илүү сайн хүргэх мэдээллийн санг хөгжүүлж, удирдах суурийг бий болгох зорилгыг хэрэгжүүлэхдээ дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Төрийн байгууллагуудын өгөгдлийн сан, тэдгээрийн удирдлагад үнэлэх;
2. Нэгдсэн мэдээллийн санг байгуулах замын зураглалыг загварчлах;
3. Замын зураглалыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах;
4. Өгөгдлийн санг хөгжүүлэх, удирдах бодлогын болон техникийн зөвлөмж боловсруулах;
5. Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага хариуцсан ажилтнуудын мэдлэг, ур чадвараар бэхжүүлэх.

### Төслийн төсөв, батлагдсан үнийн дүн

Тус төслийг 2 жилийн хугацаанд 3 төрлийн үндсэн бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж, нийт 1 сая ам.доллар зарцуулах ба эхний үр дүн буюу үнэлгээний ажилд нийт 525.2 мянган доллар (52.5 хувь), хоёрдугаар үр дүн буюу замын зураглал, эдийн засгийн үндсэн ажлын замын төлөвлөгөө боловсруулж, батлуулахад 306.4 мянган ам доллар (30.5 хувь), гуравдугаар үр дүн буюу мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх ажилд нийт 169.7 мянган доллар (17.0 хувь) төсөвлөгдсөн.

## ХҮСНЭГТ 15. ТӨРИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН ХӨГЖҮҮЛЭХ, УДИРДАХ ТӨСЛИЙН ЗАРДАЛ

1 ам.доллар = 3 420.57 төгрөг

№	Зардлын төрөл	Дүн, ам.доллар	Хуваарь				
			2023	2024	I үр дүн	II үр дүн	III үр дүн
	Дүн	1 000 000	593 217	406 783	525 230	305 095	169 676
	Хувь		59.3%	40.7%	52.5%	30.5%	17.0%
1	Төслийн удирлага, менежмент	50 000	30 000	20 000	16 667	25 000	8 333
2	Гадаадын зөвлөх	215 000	122 280	81 520	122 280	71 330	10 190
3	Мэргэжилтний цалин	200 000	136 000	204 000	136 000	151 500	52 500
4	Бараа, тоног төхөөрөмжийн зардал	200 000	193 214	24 285	193 214	24 285	-
5	Мэдлэг, ур чадвараар бэхжүүлэх зардал	110 000	45 033	29 567	-	-	74 600
6	Бусад зардал	225 000	66 690	47 411	57 069	32 980	24 052

### Төслийн үе шат, хугацаа

Төслийг дараах гурван үе шаттай хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Салбар, агентлаг хоорондын статистикийн мэдээлэл цуглуулах, удирдах, түгээх үйл ажиллагааны үнэлгээг 2023 оны 10-р сарыг хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.
  - 1.1. Төрийн байгууллагын мета өгөгдлийг судалж, дүн шинжилгээ хийх.
  - 1.2. Өгөгдөл, мэдээллийн технологийн дэд бүтэц, хүний нөөцийн зөрүүтэй байдлыг тодорхойлох
  - 1.3. Мета өгөгдөл хангалтгүй эсвэл мета өгөгдөлгүй байгууллагуудын мета өгөгдлийг шинэчлэх/ эсвэл боловсруулах алхмыг тодорхойлж, шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх
  - 1.4. Мэдээлэл цуглуулах, боловсруулах (цэвэрлэх, засварлах, баталгаажуулах, нэгтгэх), тархаах, хянах, удирдах үйл явцыг загварчилж, хэрэгжүүлэх
2. Нэгдсэн өгөгдлийн сангийн замын зураглал болон үйл ажиллагааны төлөвлөгөөний бодлогын болон техникийн зөвлөгөөг эцэслэн боловсруулах ажлыг 2023 оны 4-р улирлаас 2024 оны 3-р улирлыг дуусталх хугацаанд зохион байгуулна.
  - 2.1. Бодлого, мэдээллийн технологийн дэд бүтэц болон бусад техникийн зөвлөмжийг 2024 оны 4-р улиралд багтаан боловсруулах;
  - 2.2. Төрийн нэгдсэн өгөгдөл, мэдээллийн санг хөгжүүлэх, удирдах цогц замын зураглалыг 2024 оны 2-р улиралд багтаан боловсруулж, томьёолох;

- 2.3. Замын зураглалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг 2024 оны 2-р улиралд багтаан боловсруулах;
- 2.4. Сөнгөсөн салбарын өгөгдлийг 2024 оны 3-р улиралд багтаан нэгтгэж, туршилт тооцоо, судалгааг боловсруулж, үр дүнг үнэлж, хэлэлцүүлэх.
3. Өгөгдлийн сангийн хөгжүүлэлт, удирдлагатай холбоотой мэдлэг, ур чадвараар бэхжүүлэх ажлыг төсөл эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд зохион байгуулж, ҮСХ болон төрийн байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлнэ.
- 3.1. “Төрийн нэгдсэн мэдээллийн сан” төслийг танилцуулах үндэсний чуулган зохион байгуулах;
- 3.2. Төрийн байгууллагуудын холбогдох ажилтнуудад цуврал сургалт, семинар зохион байгуулах;
- 3.3. Төслийн хэрэгжилт дээр үндэслэн Үндэсний өгөгдлийн форум зохион байгуулах;
- 3.4. Оролцогч талуудад цуврал сургалт, семинарыг зохион байгуулах.


Төслийн 2 дахь үе шатыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ҮСХ нь АХБ болон БНСУ-ын Статистикийн газартай хэлэлцээрийг эхлүүлсэн. Хэлэлцээрийн үр дүнд төслийг 2024 оноос БНСУ-ын Хөгжлийн албан ёсны тусламжаар 4 жилийн хугацаатай үргэлжлүүлэхээр тохиролцов.

## 2.3 ДОТООД АЖИЛ

### 2.3.1 Хүний нөөц

Статистикийн байгууллага нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд Үндэсний Статистикийн Хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Статистикийн газар, хэлтсээс бүрдэн 320 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс ҮСХ-нд 123 орон тооноос 116, 21 аймгийн Статистикийн хэлтэст 129, Нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст 68 албан хаагч ажиллаж байна.

ЗУРАГ 28. ХҮНИЙ НӨӨЦ, байршил, хүйсээр



ҮСХ болон нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсүүдэд гарсан сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж, 8 удаагийн тусгай шалгалтаар 74 сул орон тоог нөхөн албан хаагчдыг томилон ажиллууллаа. Ажил гүйцэтгэх гэрээг 28 иргэнтэй байгуулан ажил гүйцэтгүүлэв.

Албан хаагчдын сэтгэл ханамжийг тодорхойлох 29, сууцны нөхцөл байдлыг тодорхойлох 7, ерөнхий мэдээллийг тодорхойлох 4 асуулт боловсруулж, 76 албан хаагчаас сэтгэл ханамжийн судалгаа цахимаар авч, судалгааны үр дүнг нэгтгэн, үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна.

Хууль тогтоомжийн дагуу 92 албан хаагчид зэрэг дэв, 32 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 54 албан хаагчдад буцалтгүй тусламж дэмжлэг олгов.

ҮСХ-ны албан хаагчдын ур чадварын үнэлгээний 3 бүлгийн 18 асуулт бүхий 3 төрлийн асуулга (өөрийгөө, хамтран ажиллагаа, удирдах ажилтнаа үнэлэх)-аар авсан судалгаанд 106 албан хаагч хамрагдсан. Үнэлгээнд тулгуурлан салбарын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлд хувь хүний хөгжил, манлайлал, статистик үзүүлэлтийн арга зүй, аргачлал, статистикийн программыг мэдлэг олгох, сургагч багш бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 623 албан хаагчийг хамрууллаа.

Статистик, эдийн засаг, мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байгаа 70 оюутныг ҮСХ-ны газар, хэлтсүүдэд үйлдвэрлэлийн дадлага хийлгэх ажлыг зохион байгуулав.

Хүний нөөцийн хөгжлийг хангах стратегийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ҮСХ-ны даргын 2022 оны А/207 дугаар тушаалаар “Статистикийн

байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг баталсан. Бодлогын баримт бичигт:

- Албан хаагчийн карьер хөгжлийг тодорхойлох "Албан тушаалын шатлал, хөгжлийн зураглал";
- Шинээр томилогдсон албан хаагчийг салбарт дасан зохицох чиглэлд "Шинээр томилогдсон албан хаагчийн дасан зохицох хөтөлбөр хариуцсан нэгжийн ажлын дараалал";
- Албан хаагчийг чадавхжуулах, тухайн жилд суралцах чиглэлийг тодорхойлох "Сургалтын жилийн багц төлөвлөгөө";
- Албан хаагч бүрийн ажлыг гүйцэтгэлийг гүйцэтгэлд суурилсан байдлаар үнэлэх чиглэлд "Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх";
- Тус бодлогын хэрэгжүүлэх ажлыг "Салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 2023-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө" гэсэн бүтэцтэйгээр батлан хэрэгжүүлж эхлээд байна.

### 2.3.2 Дотоод ажлын цахимжилт

Байгууллагын дотоод ажлын цахимжилтын хүрээнд 2022 оны 4 дүгээр сараас цахим хяналтын системийг нэвтрүүлж, нийт 1114 албан бичиг, тушаалын төслийг хянаж албажууллаа.

Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журам, ҮСХ-ны даргын тушаалаар батлагдсан арга аргачлал, маягт зааврыг цахимжуулан 1989-2022 оны 154 дүрэм журам, 132 арга аргачлал, 444 маягт зааврын цахим архив үүсгэн албан хаагчид дотоод үйл ажиллагаандаа ашиглаж байна.

"Төрийн байгууллагын нэгдсэн удирдлагын систем /ERP/"-ээр 1157 албан бичгийг бүртгэн хүлээн авч, 1167 албан бичиг бусад байгууллагад явуулсан байна. Нийт 685 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу албажуулсан. ҮСХ-нд 2022 онд иргэд, албан хаагчдаас нийт 344 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

Байгууллагын архивд 387 хадгаламжийн нэгжийг хүлээн авч бүрдүүлэлт хийсэн бөгөөд байгууллагын архивд хадгалагдаж буй 1950 оноос 2020 оны нийт 2074 хадгаламжийн нэгжийг цэгцэлж, данс бүртгэлийг шинэчлэв.

### 2.3.3. Санхүү, хөрөнгө оруулалт

Үндэсний Статистикийн Хорооны 2022 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 15644.0 сая төгрөгөөр батлагдаж, 2022 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 14005.2 сая төгрөгийг урсгал санхүүжилтэд авч, 13707.0 сая төгрөг зарцуулсан.

Хөрөнгө оруулалтын зардалд 2158.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2128.3 сая төгрөг зарцуулж тайлант хугацаанд өр, авлага үүсгэлгүй ажилласан бөгөөд байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явагдах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж ажиллалаа. ҮСХ-ны дүнгээр 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

**ЗУРАГ 29. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ, эдийн засгийн ангиллаар, сая төгрөг**



Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Говь-Алтай, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий гэсэн 12 аймгийн статистикийн хэлтэст тусгай тоноглол бүхий автомашин төсвийн хөрөнгө оруулалтаар олгож, ажиллах нөхцөл боломжоор хангалаа.

Салбарын хэмжээнд бүх автомашинд GPS төхөөрөмж суурилуулснаар мэдээлэл цуглуулагч, жолооч нарын аюулгүй байдлыг хангаж, судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлын явц, төсвийн зарцуулалтад зайнаас хяналт боломжийг бүрдүүлсэн.

Төсвийн шууд захирагчийн 23 байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авч шалгаж, нэгтгэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлан тэнцлийг гаргаж Үндэсний аудитын газарт шалгуулан “Зөрчилгүй” санал, дүгнэлт хүлээн авав.

## 2.4 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад сургалт, арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх, сургалтын шинэ төрөл, хэлбэрүүдийг хамруулах зорилгоор Статистикийн салбарын гадаад сургалт, арга хэмжээг зохицуулах журмыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Гадаад сургалт, арга хэмжээнд албан хаагчдыг нэр дэвшүүлэхэд санал авах ажиллагааг цахимжуулав.

2022 онд олон улс болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 61 удаагийн гадаад арга хэмжээнд давхардсан тоогоор 113 албан хаагчийг оролцууллаа. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагууд, дипломат төлөөлөгчийн газруудад “Статистик – Хэрэглэгч” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулсан.

Олон улсын байгууллага, гадаад улсын эрдэмтэн судлаач, хэрэглэгчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу холбоотой тоо мэдээллийг тухай бүр гарган өгч ажилласан.

#### 2.4.1 Олон талт хамтын ажиллагаа

НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийг бэхжүүлэх, хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах, статистикийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал,

- НҮБ-ын Статистикийн комиссын 53 дугаар чуулган болон тус чуулганы үеэр зохион байгуулагдсан 46 салбар хуралдаанд ҮСХ-ны удирдлага, төлөөлөгчид оролцож, хэлэлцсэн 21 асуудал, танилцуулах 4 асуудалд ҮСХ-ны байр суурь, саналыг боловсруулан танилцуулсан.
- Ази, Америк, Номхон далайн орнуудын үндэсний тооллого, статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэгийн Хүн амын тооллогын 31 дүгээр бага хуралд ҮСХ-ны дарга оролцож, тус нийгэмлэгийн дэд ерөнхийлөгчөөр 2022-2024 онд сонгогдон ажиллахаар болов. 2024 онд Хүн амын тооллогын 32 дугаар бага хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар ажиллаж байна.
- НҮБ-ын АНДЭЗНК-ын Статистикийн хорооны 8 дугаар хурал, ПАРИС21-ийн Удирдах зөвлөлийн хурал, НҮБ-ын Статистикийн хэлтсээс зохион байгуулсан “Их өгөгдөл болон өгөгдлийн шинжлэх ухааны албан ёсны статистик” сэдэвт олон улсын 7 дугаар бага хурал, Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтүүдийн асуудлаарх Бүс дундын шинжээчдийн бүлгийн гишүүдийн 13 дахь уулзалтад холбогдох албан хаагчид оролцсон.
- НҮБ-ын Хөгжлийн дансны санхүүжилтээр НҮБ-ын АНДЭЗНК-оос хэрэгжүүлж байгаа “Үндэсний статистикийн системийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын нэвтрэлтийг эрчимжүүлэх, үндэсний статистикийн системийн албан хаагчдад чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын материаллаг баазыг сайжруулах, цахим сургалт платформ байгуулах төслийг хэрэгжүүлэхээр боллоо.
- Дэлхийн Банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Ухаалаг засаг” төслийг 2016-2022 онд амжилттай хэрэгжүүллээ.
- НҮБ-ын Хүн амын сангаас Улс орныг дэмжих 5 жилийн хугацаатай 7 дугаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан.
- НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний олон улсын байгууллагатай хамтран Монгол Улсаас гадаадад оршин суугаа иргэдийн судалгааны үзэл баримтлалыг боловсруулсан.
- НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа”-ны үр дүнгийн тархаалтыг хийж, хүүхэд, гэр бүлтэй холбоотой постер, видео контент зэргийг бэлтгэн тархаасан.
- НҮБ-ын Статистикийн хэлтсээс ирүүлсэн “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал”-ын шинэчилсэн хувилбарт санал боловсруулж хүргүүлсэн.

## 2.4.2 Хоёр талт хамтын ажиллагаа

Цар тахлын улмаас салбарын хоёр талт хамтын ажиллагаа харьцангуй зогсонги байдалд орсон байсан хэдий ч уламжлалт харилцаа, хамтын ажиллагаа хэвээр хадгалах, хөгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

- Хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах хүрээнд 14 орны статистикийн байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна.
- БНСУ-ын Статистикийн газраас албан ёсны статистикт их өгөгдлийг ашиглах, Швейцарын Статистикийн газраас Үндэсний өгөгдлийн менежмент, Сингапурын статистикийн газраас хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх стратегийн чиглэлээр туршлага судалж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.
- БНСУ-ын Статистикийн газраас хэрэгжүүлэх албан ёсны буцалтгүй тусламжийн төсөлд хамрагдах хүсэлтээ хүргүүллээ.
- Австралийн Статистикийн товчоотой байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг сунгах хүсэлт хүргүүлж, хамтран ажиллаж байна.
- Гүржийн Үндэсний Статистикийн Газартай статистикийн салбарт хамтран ажиллах, туршлага судлах харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

## 2.5 ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### 2.5.1 Дотоод аудитын үйл ажиллагаа

ҮСХ-ны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм болон Сангийн Яамнаас баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу “Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсруулан баталж, хэрэгжүүлж эхлээд байна.

ҮСХ-ны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалт, аудитыг ҮСХ-ны даргын баталсан Дотоод аудит, хяналт шалгалтын хуваарийн дагуу зохион байгуулсан.

- Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа нэгжүүдийн 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит, Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит буюу нийт 24 дотоод аудитыг хийсэн.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 оноос хойш байнгын хяналт тавьж, дотоод аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж хүргүүлж ажилласны үр дүнд шилэн дансны үйл ажиллагаа сайжирсан. Тухайлбал, Шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээллийн хугацаа хоцролт 2016 онд 37.5 хувь байсан бол 2022 онд 0.4 хувь болж буурсан, хугацаандаа мэдээлсэн байдал 99.6 хувьтай байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн шууд захирагч нарын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын байгууллагаас өгсөн 1 акт, 5 албан шаардлага, 19 зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулан, биелэлтийн нэгтгэлийг Үндэсний Аудитын Газарт хүргүүлсэн.

Дотоод-аудит, хяналт шалгалтын хуваарийн дагуу 2022 онд төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 11 буюу нийт 14 дотоод хяналт шалгалтыг бүрэн хийсэн. Тухайлбал, Нийгмийн статистикийн газар, Тамгын газар, Эдийн засгийн статистикийн газар, Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын үйл ажиллагаанд болон дундаж цалин, боловсролын салбарын статистик мэдээлэл, “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн мэдээллийн баяжуулалт, “ҮСХ-нд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс 2021 онд ирүүлэх мэдээ, тайлангийн график”, “Өрхөд суурилсан судалгааны хяналтын ажил”, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын ажил дүгнэх журмын хэрэгжилтэд тус тус дотоод хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг өгсөн.

Дотоод хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажилласнаар статистикийн мэдээлэл цуглуулах, хянаж шалгах, боловсруулах, тархаах үе шатанд илэрсэн зөрчлүүдийг шуурхай засан залруулж, зөрчил давтан гарахгүй байх нөхцөлийг ҮСХ-ны бүх нэгж, ажилтан бүрдүүлэн ажиллаж байна.

### 2.5.2 Эрсдэлийн удирдлага

НҮБ-ын Европын Эдийн засгийн Комисс (UNECE)-оос статистикийн байгууллагуудыг шинэчлэхэд чиглэсэн санаачилгын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх “Статистикийн байгууллагын эрсдэлийн удирдлагын практик удирдамж”-ийн дагуу “ҮСХ-ны эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, ҮСХ-ны даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар баталж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгов.

Мөн ҮСХ-ны даргын 2022 оны А/67 дугаар тушаалаар “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-ыг баталж, ҮСХ-ны даргын 2022 оны А/76 тушаалаар ҮСХ-ны Эрсдэлийн зөвлөл болон ҮСХ, аймаг, нийслэлийн үйл ажиллагааны эрсдэлийг удирдах орон тооны бус нэгжийг байгуулан эрсдэлийн удирдлагын үйл явцыг удирдан ажиллаж байна.

Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар 2022 онд мэдээллийн технологийн үйл ажиллагаанд эрсдэлийн шинжилгээ хийж, эрсдэлийг арилгах, бууруулах, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

“Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-ын дагуу Эрсдэлийн мэдээллийн сан байгуулах бодлогын даалгаврыг анхан шатны мэдээллийн чанарыг сайжруулах багц журмуудтай уялдуулан боловсруулсан. ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнуудад зориулж “Статистикийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын гарын авлага”-ыг бэлтгэн, хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаасан.

“Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, холбогдох гарын авлагын дагуу ҮСХ-ны газар болон аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын орон тооны бус нэгжүүд нь эрсдэлийн үнэлгээг хийж, албан ёсны статистикийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийн үнэлгээ, бүртгэлийг хийсэн. Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас эрсдэлийн үнэлгээ, бүртгэлийг судалж, дүн шинжилгээ хийж нягтлан “маш өндөр”, “өндөр”, “дунд” эрсдэлийг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

## 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОМООХОН АЖЛУУД

### 1. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах

Хуулийн төслийг боловсруулах тандан судалгааны тайлан, үзэл баримтлал болон хуулийн бичвэрийн эхний төсөд бэлэн болсон. 2023 онд Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, хууль санаачлагчид өргөн барина.

### 2. Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах “Төрийн их өгөгдөл” төсөл хэрэгжүүлэх

Төслийн хүрээнд 2023 онд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

- 20-иос доошгүй төрийн байгууллагын мета өгөгдөл, статистикийн өгөгдөл, мэдээллийн технологийн дэд бүтэц, хүний нөөцөд үнэлгээ, дүн шинжилгээ хийж, өгөгдөл цуглуулах, цэвэрлэх, стандартчилах, баталгаажуулах, нэгтгэх, тархаах, удирдах үйл явцыг загварчилж, замын зураглалыг боловсруулна.
- Өгөгдөл цуглуулах, цэвэрлэх, стандартчилах, баталгаажуулах, нэгтгэх, тархаах, удирдах үйл явцын замын зураглалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний төслийг боловсруулна.
- Төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг нэгтгэж, вэйрхаус үүсгэнэ.
- Дараах төрийн байгууллагуудын өгөгдөл, мэдээллийн сангуудыг туршилтаар нэгтгэж, шийдвэр гаргалтад ашиглах боломжийг бүрдүүлнэ.
  - Статистикийн өгөгдөл, мэдээллийн сангуудыг нэгтгэх
    - Өрх, хүн ам (ХӨАМС + АХС + ӨНЭЗС + Мал тооллого)-ын мэдээллийн сан бүрдүүлэх;
    - Бизнес эрхлэгч (СБР + ААНБ + Мал тооллого + ХАӨМС + SPS)-ийн мэдээллийн сан бүрдүүлэх;
  - Төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг нэгтгэх
    - Өрх, хүн амын мэдээллийн сан бүрдүүлэх (ХӨАМС + АТҮТ + ТЕГ + НДЕГ + УБЕГ + Бусад);
    - Бизнес эрхлэгчийн мэдээллийн сан бүрдүүлэх (СБР + АТҮТ + ТЕГ + ГТСМТТ + НДЕГ + УБЕГ + СЯ + Бусад)

### 3. Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах

Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр онцгой анхаарч, статистикийн өгөгдөл мэдээллийн сан, түүвэр судалгааны өгөгдөл мэдээлэл цуглуулах, тархаах үзүүлэлтийн уялдааг хангахад мөрдөх багц журмыг хэрэгжүүлж, үйл ажиллагааг сайжруулна.

## 4. Гар утас, газарзүйн мэдээллийг статистикт ашиглах

### 4.1. Гар утасны мэдээллийн ашиглах

Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага болон Оксфордын их сургуулийн технологи, хөгжлийн төвтэй хамтран үүрэн холбооны өгөгдөлд суурилсан хүн амын дотоод шилжилт хөдөлгөөнийг тандах туршилт судалгааны хүрээнд 2023 онд үүрэн холбооны оператор компаниас дуудлагын дэлгэрэнгүй бүртгэл - Call Detail Records (CDR) буюу гар утасны задгай өгөгдлийг хуваалцах гэрээг байгуулж, өгөгдлийг хүлээн авахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Өгөгдөл, мэдээллийн нууцыг хадгалах зорилгоор хэрэглэгчид, утасны дугаарыг танигдахгүй болгон кодлох, өөрчлөх замаар өгөгдлийг нэгтгэж, Sci-kit mobility, Bandicoot, OPAL зэрэг хөдөлгөөнт CDR өгөгдлийг боловсруулах хэрэгслүүдийг ашиглан, сошиал медиа, хиймэл дагуулын дүрслэл, хүн ам, нийгмийн судалгааны өгөгдлийн сан зэрэг бусад мэдээллийн эх сурвалжтай уялдуулан үр дүнг боловсруулан гаргана.

Судалгаагаар хүн ам зүй, хот төлөвлөлт, эмнэлэг, сургуулийн дэд бүтцийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, Монгол Улсын хэмжээнд хүн амын хөдөлгөөнт байдлын зураглалыг багтаасан зөвлөмжийг боловсруулна.

#### Төслөөс гарах дүн

- Хүн амын улсын болон орон нутгийн чанартай дотоод шилжилт хөдөлгөөний урсгалыг үнэлэх
- Хүн амын хот доторх шилжилт хөдөлгөөний урсгалыг үнэлэх
- Улирлын чанартай аялал жуулчлалын хөдөлгөөний урсгалыг үнэлэх

### 4.2. Газарзүйн мэдээллийг ашиглах

Хаягийн орон зайн мэдээллийг ашиглан өрх, аж ахуйн нэгж, байгууллагын байршлыг тодорхойлох: ҮСХ нь хаягийн орон зайн мэдээллийг ашиглан өрх, аж ахуйн нэгж, байгууллагын байршлыг тодорхойлж, статистикийн үйлдвэрлэл, бодлого боловсруулалт, судалгаа, шинжилгээнд ашиглах зорилготой.

Хаягийн орон зайн мэдээлэл нь хаягийн бичвэрийг байршилд хөрвүүлсэн (geocode) мэдээллийн сан хэлбэрээр үүсдэг ба хаягийн бичвэрийг ашиглан тодорхойлсон байршлаас хаяг тодорхойлох боломж бүхий мэдээллийн сан юм. Дараах үйл ажиллагааг 2023 онд хэрэгжүүлнэ. Үүнд:

- ГЗБГЗЗГ-ын хаягийн мэдээллийн сангийн сервис авч ашиглах;
- ГЗБГЗЗГ-ын хаягийн мэдээллийн сантай ХАӨМС, СБР сангуудад хаягийн бичвэрээр тулгалт хийх;
- ХАӨМС-ийн өрхийн хаягийн бичвэр, статистикийн бизнес регистрийн сангийн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн хаягийн бичвэрийг хаягийн орон зайн мэдээллийн системд шилжүүлж/хөрвүүлж байршил тодорхойлох;
- Хаягийн бичвэр таараагүй хаягуудыг ХАӨМС, СБР-рт засварлаж, шинэчлэх.

Сансрын зураг ашиглан зайнаас тандан судлах аргын тусламжтайгаар тариалангийн талбайн байршил тодорхойлох: Өмнөх жилүүдэд Random Forest машин сургалтын арга болон ХААТ-ийн хүрээнд Spectral Angle Mapper аргуудыг боловсруулж туршилт хийсэн. 2023 онд дээрх аргуудыг ашиглан бүс нутаг, ургамлын төрлийг сонгож, туршилт тооцооллын тусламжтайгаар давуу, сул талыг тодорхойлж, статистикийн тооцоололд ашиглах, нэвтрүүлэх боломжийг судалж тогтооно.

#### **5. Төрийн нэгдсэн мэдээллийн сан (ТНМС)-г шийдвэр гаргалтад ашиглах**

Статистик болон төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг нэгтгэж, вэйрхаус үүсгэн нэгдсэн мэдээллийн сан байгуулж, хүн ам, өрх, бизнес эрхлэлтийн дараах дүн шинжилгээнүүдийг боловсруулж, шийдвэр гаргалтад ашиглах төлөвлөгөөтэй байна. Үүнд:

1. Зорилт бүлгийг тодорхойлох орлого орлуулан тооцох аргачлалыг боловсронгуй болгох, өгөгдөл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх шаардлагатай орчинг бүрдүүлэх, тодорхой загвар архитектурын дагуу өгөгдлийн нэгтгэл сан (data warehouse) үүсгэх;
2. ӨНЭЗС, НӨАТУС-ын мэдээлэлд үндэслэн өрхийн хэрэглээ, ААН-ийн орлого, зардлын судалгаа боловсруулах;
3. ХАОСТ-ын 1989, 2000, 2010, 2020 оны нийт 40 жилийн мэдээллийг ашиглаж нийгмийн шилжих хөдөлгөөний судалгаа боловсруулах;
4. Мета өгөгдлийн платформын шийдлийг боловсруулж турших, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;
5. Зайнаас тандан судлах технологи ашиглан тариалангийн ургацын төрлийг тооцох олон улсын туршлага аргазүйг судалж, туршилт тооцоо, судалгаа шинжилгээний ажил боловсруулах.

## ГУРАВ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар тогтоолын дагуу Үндэсний Статистикийн Хорооны 2022 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээг танилцуулж байна.

Системчилсэн үнэлгээг Хууль зүйн яам (тухайн үеийн нэрээр)-наас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийв. Түүнчлэн ҮСХ-ны 2022 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад баримт материалыг судалж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд зарим асуудлыг тодруулахад санал асуулга авсан.

ҮСХ-ны 2022 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээнд чиг үүргийн хэрэгжилт, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хамруулав.

### ХҮСНЭГТ 16. ҮСХ-НЫ 2016-2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СЭДЭВ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА

Он	Үнэлгээний		Арга сонгосон шалтгаан/тайлбар
	Сэдэв	Арга	
2017	ҮСХ-ны 2016 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>Баримт бичиг судлах</li> <li>Ажиглалт хийх</li> </ul>	Албан ёсны статистикийн үйл ажиллагаа нь салбарын хэмжээнд тасралтгүй үргэлжилдэг учраас үнэлгээний тайланд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын албан ёсны статистиктай холбоотой үйл ажиллагаа орсон.
2018	ҮСХ-ны чиг үүрэг, хүний нөөцийн хэрэгцээ	<ul style="list-style-type: none"> <li>Баримт бичиг судлах</li> <li>Ажиглалт хийх</li> <li>Санал асуулга авах</li> </ul>	Ажлын байрны зорилго, ажилтны чиг үүргийн уялдаа, ажлын ачаалал болон ажлын байран дахь сэтгэл ханамжийн талаар тайланд тусгасан учир 3 аргыг хослуулан хэрэглэсэн.
2019	Анхан шатны нэгжид мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ	<ul style="list-style-type: none"> <li>Баримт бичиг судлах</li> <li>Ярилцлага хийх</li> <li>Санал асуулга авах</li> </ul>	Анхан шатны нэгжээс мэдээлэл цуглуулах, нэгтгэх, хянаж шалгах үйл ажиллагаа, хүний нөөц, орон тоо, бүтцийн талаар үнэлгээ хийсэн.
2020	ҮСХ-ны 2019 оны үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Баримт материалыг судлах</li> <li>Дүн шинжилгээ хийх</li> <li>Санал асуулга авах</li> <li>Баримт материалыг судлах</li> </ul>	ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, үйл ажиллагааны журам (процессын), хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.
2021	ҮСХ-ны 2020 оны үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Баримт материалыг судлах</li> <li>Дүн шинжилгээ хийх</li> <li>Санал асуулга авах</li> </ul>	ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.
2022	ҮСХ-ны чиг үүрэг, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээ	<ul style="list-style-type: none"> <li>Баримт материалыг судлах</li> <li>Дүн шинжилгээ хийх</li> <li>Санал асуулга авах</li> </ul>	ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээг хамруулсан.
2023	ҮСХ-ны чиг үүрэг, төсөв санхүүгийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Баримт бичиг судлах</li> <li>Ажиглалт хийх</li> </ul>	ҮСХ-ны чиг үүрэг, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.

## 1. ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

### 1.1. Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2: “Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. ...” гэж заасны дагуу ҮСХ-нд 116, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст 68, 21 аймгийн статистикийн хэлтэст 129, нийт 320 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан ҮСХ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах 7 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн ажиллажээ. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Өгөгдлийн удирдлагыг боловсронгуй болгох;
3. Албан ёсны статистикийн шинэчлэлийг хэрэгжүүлэх;
4. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
5. Албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргах;
6. Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн гаргаж, мөрдөх;
7. Статистикийн мэдээллийн тархаалтыг шинэлэг хэлбэрээр өргөтгөх.

ҮСХ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан газар, нэгжүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулж, төрийн албан хаагчид чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх ажлуудыг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлжээ.

ҮСХ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.5 хувьтай байна. Биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлэхэд 13 ажил бүрэн хэрэгжсэн<sup>1</sup>, 3 ажил хэрэгжих шатандаа<sup>2</sup> байна.

<sup>1</sup> “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

<sup>2</sup> “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

ХҮСНЭГТ 17. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

№	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэсэг	Зорилтын тоо	Төлөвлөсөн ажлын тоо	Хэрэгжилтийн үнэлгээ			
				Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй
	<b>Нийт</b>	<b>7</b>	<b>16</b>	<b>13</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>
	Нэгдүгээр хэсэг.						
1	Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	6	13	10	3	-	-
	Хоёрдугаар хэсэг.						
2	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	1	3	3	-	-	-

Хэрэгжих шатандаа байгаа буюу 70 хувийн биелэлттэй 3 ажлын шалтгааныг тодруулбал:

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1-д “Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах, хууль санаачлагчид танилцуулах” ажлыг төлөвлөсөн ч зорилтот түвшинд хүрээгүй шалтгаанаар 2023 оны төлөвлөгөөнд шилжүүлсэн байна.
2. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.4-т “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын системийн ISO-27000 стандартыг нэвтрүүлэх” ажлын хүрээнд ISO 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын системийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, үе шатны талаар сургалт авч, хэлэлцүүлэг, үнийн судалгаа хийгдсэн. Хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөх болон аудитын үйлчилгээ авах төсөв шийдэгдээгүй тул 2023 оны төлөвлөгөөнд шилжүүлсэн.
3. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.1-т “Статистикийн 6 аргачлал, арга зүйг олон улсын стандартын дагуу шинэчлэн сайжруулах”-аар төлөвлөсөн байна. Үүнээс Хэрэглээний үнийн индексийн суурь, Орон сууны үнийн индексийг хедоник регрессийн аргаар тооцох аргачлалыг эхний хувилбар, ДНБ-ний суурь шинэчлэх тооцоолол, БОЭЗДС-ийн ХАА-н данс байгуулах аргачлал, Эрчим хүчний статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, Орлого орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал, Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлалыг боловсруулан батлуулж, Олон хэмжээст ядуурлын аргачлалыг шинээр, Амьжиргааны доод түвшинг тооцох аргачлалыг шинэчлэн батлуулаагүй байна.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Бүрэн хэрэгжсэн<sup>3</sup>” гэж үнэлсэн боловч зарим шалтгааны улмаас 90 хувьтай үнэлэгдсэн ажлуудыг тодруулбал:

1. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2.3-т “Албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг гаргахад төрийн их өгөгдлийг ашиглах бэлтгэл хангаж төрийн байгууллагын өгөгдлийн сантай холбосон статистикийн мэдээний тоогоор дүгнэх”-ээр төлөвлөжээ. Энэ ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан ч төрийн байгууллагын өгөгдлийн сантай холбох ажил нь бусад байгууллагаас шалтгаалж бүрэн дуусаагүй байна.
2. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1-т “Статистикийн мэдээлэл боловсруулалтад цахим арга хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн систем-SPS-ийн ашиглалтыг нэмэгдүүлж, тус системийг ашиглан 50 мэдээг цуглуулж, боловсруулах”-аар төлөвлөснөөс 40 мэдээг шилжүүлж, нэмэлт хөгжүүлэлт шаардлагатай 10 мэдээг шилжүүлж дуусаагүй байна.

ҮСХ нь статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх, албан ёсны статистикийн үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн чанар болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улам сайжруулах зорилгоор мөрдөж буй дүрэм, журам, бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлээр 2022 онд санаачилгатай ажилласан байна. Үүнд:

- ✓ Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх ажлын хүрээнд 7 аргачлал, 9 тооллого, судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар, 6 багц маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн баталсан;
- ✓ “Статистикийн байгууллагын мэдээлэл тархаалтын журам”-ыг баталсан;
- ✓ ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүдээс гаргаж буй статистикийн бүтээгдэхүүнийг нэг стандарт, загварын дагуу боловсруулан хэрэглэгчдэд тархаах чиглэлээр “Статистикийн бүтээгдэхүүн бэлтгэх загвар”-ыг шинэчлэн баталсан;
- ✓ Статистикийн салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан;
- ✓ Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах 5 багц журмыг шинэчлэн баталж, мөрдөж эхэлсэн. Үүнд:
  - Статистикийн мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам;
  - Арга зүйн байнгын зөвлөлийн ажиллах журам;
  - Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгааны мэдээлэл цуглуулах багийн ажиллах журам;

<sup>3</sup> “Бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

- Хүн ам, өрхийн мэдээллийн санг хөтлөх, ашиглахад баримтлах журам;
  - Статистикийн бизнес регистрийг хөтлөх, ашиглах журам.
- ✓ Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгосон;
  - ✓ Дээрх бодлогын баримт бичгийн хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журмыг боловсруулан баталж, Эрсдэлийн зөвлөл болон ҮСХ, аймаг, нийслэлийн үйл ажиллагааны эрсдэлийг удирдах орон тооны бус нэгжийг байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлж эхэлсэн;
  - ✓ ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнуудад зориулж Эрсдэлийн удирдлагын гарын авлагыг бэлтгэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цахим хэлбэрээр хүргүүлсэн;
  - ✓ “Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлсэн;
  - ✓ ҮСХ-ны даргын баталсан Дотоод аудит, хяналт шалгалтын хуваарийн дагуу үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалт, аудитыг зохион байгуулсан. Төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 14 дотоод хяналт шалгалтыг хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар ҮСХ-ны бүх нэгж, ажилтан үйл ажиллагаагаа улам сайжруулахад анхаарч ажиллаж байна.
  - ✓ Дотоод үйл ажиллагаа, тооллого, судалгааг цахимжуулж зардал хэмнэсэн;

ҮСХ-ны даргын 2021 оны А/238 дугаар тушаалаар 2022 онд албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны үр дүнг тархаах хуваарь, ҮСХ-нд яам, төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсээс ирүүлэх мэдээний хуваарийг тус тус баталж холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангасан байна.

ҮСХ нь албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлт тооцох мэдээллийг захиргааны болон албан ёсны мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар цуглуулан боловсруулж, тархаажээ.

Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийслэл, 20 аймгийн өрхөд суурилсан судалгааны багийн мэдээлэл цуглуулалтын явцад хяналт хийж, хугацаатай үүрэг чиглэл, зөвлөмжүүдийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Тайлант жилд 2 тооллого, 23 түүвэр судалгааг зохион байгуулсан байна. Үүнээс Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоолд Хөдөө аж ахуйн ээлжит тооллого

явуулахаар заасан хугацаанд Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамтай хамтран Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын гишүүн орнуудад зөвлөмж болгосон ХАА-н дэлхийн хөтөлбөрт тусгагдсан үзүүлэлт, зөвлөмж, нэгдсэн аргачлалын дагуу нэлэнхий болон түүвэр судалгааны холимог арга зүйгээр зохион байгуулж, тооллогын үндсэн үр дүнг олон улстай харьцуулах боломжийг бүрдүүлжээ.

Тооллогын мэдээлэл цуглуулалтыг таблет ашиглан газар зүйн мэдээллийн системтэй уялдуулан зохион байгуулж, өндөр нарийвчлалтай сансрын зургийн мэдээллээр тариалангийн талбайн байршил, өрх, ААНБ-ын байршлын цэгийг тэмдэглэснээрээ өмнөх тооллогоос онцлог болсон байна.

Статистикийн тухай хуулийн хүрээнд мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого, хагас жилийн малын түүвэр судалгаа, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, ардчилсан засаглал судалгаа, салбаруудын үнийн судалгааг хийжээ.

Хамтын ажиллагааны хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн захиалгаар “Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа”-г 3 аймагт, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, Албан хөдөлмөр эрхлэлтийн хавсарга судалгаа, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа, ХБНГУ-ын Боловсролын яамны санхүүжилтээр Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгааг тус тус зохион байгуулсан байна.

Албан ёсны статистикийн мэдээллийг яам, төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсээс ирүүлэх хуваарийн дагуу цуглуулан авч, нэгтгэн боловсруулж Монгол Улсын нийгэм эдийн засгийн сарын болон бусад танилцуулгад тусгасан байна.

Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ) болон үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг бий болгох ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэжээ. Үүнд:

- ТХЗ-ын 247 үзүүлэлтээс үндэсний түвшинд гаргах боломжтой 132 үзүүлэлтийг ҮСХ болон төрийн бусад байгууллагаас цуглуулсан 2021 оны мэдээллээр шинэчилж, Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хянах нэгдсэн системд тархаажээ.
- ТХЗ-ын 2.2.3. эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалт, 5.с.1. жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор төсөв хуваарилах, хянах тогтолцоотой эсэх, 9.b.1. боловсруулах салбарын нийт нэмэгдэл өртөгт дунд болон өндөр технологитой үйлдвэрийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь зэрэг 6 үзүүлэлтийг шинээр тооцсон байна.

- Шинжлэх ухааны академи, Удирдлагын академитай хамтран Тогтвортой хөгжлийн зорилтын 16.7.2 шалгуур үзүүлэлт буюу шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт итгэдэг хүн амьн хувийг тооцох туршилт судалгааг зохион байгуулж, ӨНЭЗС-ны өгөгдөлтэй холбож үр дүнг тооцсон байна. Тус үзүүлэлтийг Ардчилсан засаглал судалгааны асуулгад асуулт нэмж тогтмол тооцож боломжийг бүрдүүлжээ.
- АНДЭЗНК-той хамтран “Их өгөгдөл ашиглан байгаль орчин, жендэрийн үзүүлэлтийг тооцох нь” төслийн хүрээнд их өгөгдөл ашиглан ТХЗ 11.1.1-ийг тооцох оролдлогыг хийж, Дэлхийн ажиглалтын мэдээлэл (Earth Observation Data) ашиглан гэр сууцны байршлыг тодорхойлж, үүнийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-гийн өгөгдөлтэй уялдуулан Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн түвшинд хүн ам зүйн үзүүлэлтүүдийг туршилтаар тооцсон байна.

УИХ-ын санаачилгаар хэрэгжиж буй “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдөл” төслийг Азийн хөгжлийн банкны 1.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр болж, санамж бичгийг байгуулсан байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бодлого, түүний үр нөлөөг оновчтой тодорхойлох, төсвийн зардлыг хэмнэх, төрийн байгууллагуудын мэдээллийн зөрүүтэй байдал буурч, мэдээллийн уялдааг хангах, нэгдсэн стандартыг бий болгох, мэдээлэгчийн ачааллыг бууруулах, статистикийн мэдээллийн чанар улам сайжирч, түүнд үндэслэсэн шийдвэр гаргалт илүү оновчтой болох юм.

ҮСХ нь “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдөл” төслийн бэлтгэл ажлын хүрээнд бусад төрийн байгууллагуудтай хамтран ажлын хэсэг байгуулж, шаардлагатай баримт бичгүүдийн төслийг боловсруулж, батлуулсан байна. Үүнд:

- ✓ “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах журам”, “Нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам” боловсруулах үүрэг бүхий 9 байгууллагын 15<sup>4</sup> хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, журмын төслүүдийг боловсруулсан байна. Эдгээр журмын төслүүд Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл журам”, хоёрдугаар хавсралтаар “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан байна.
- ✓ “Цахим хэлбэрээр үүсэх нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, тайлбар боловсруулах үүрэг бүхий 5 байгууллагын 9<sup>5</sup> хүний бүрэлдэхүүнтэй

<sup>4</sup> ҮСХ-ноос 6, Хүний зэвсгийн комиссоос 1, ЗДХЗ-аас 1, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 1, Хувь зүй, дотоод хэргийн яамнаас 1, Галнуулагч ерөнхий газраас 1, Үндэсний дата төвөөс 1, Харилцаа, холбооны зохицуулах хорооноос 1, Мэдээлэл, холбооны операторуудын ассоциациас 1, Монгол Улсын их сургуулиас 1;

<sup>5</sup> ҮСХ-ноос 4, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 1, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 1, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 1, Харилцаа, холбооны зохицуулах хорооноос 1, Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас 1;

ажлын хэсгийг байгуулж, тус төслийг боловсруулан ҮСХ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны А/193, А/79 дүгээр тушаалаар баталжээ.

Тооцоо, судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх, ач холбогдлыг таниулах чиглэлээр 2 тооцоо, 6 судалгаа, 5 шинжилгээг хийж нийтийн хүртээл болгожээ. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг сар бүр, ДНБ-ий тооцоог улирал бүр, статистикийн жилийн эмхэтгэл, салбарын танилцуулгыг жил бүр, тооллого, судалгааны үр дүн, хэтийн тооцоо, судалгаа, шинжилгээний ажлыг тухай бүр хэрэглэгчдэд хүргэсэн байна.

Мэдээллийн шинэ эх үүсвэр бий болгох, зорилтот хэрэглэгч буюу бодлого боловсруулагч, олон улсын байгууллагуудыг мэдээллээр хангах хүрээнд ДНБ-ийг сарын давтамжтай туршилтаар тооцож, үр дүнг 6 дугаар сараас эхлэн албан хэрэгцээнд ашиглуулахаар тархаасан байна.

ҮСХ нь 2022 онд дэлхийн статистикийн байгууллагуудын мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдлыг 2 жил тутамд үнэлдэг “Open Data Watch” байгууллагын үнэлгээгээр Зүүн азийн бүс нутагт I байр эзлэн өмнөх амжилтаа бататгаж, 192 орноос VIII байрт эрэмбэлэгдэж, 2020 оноос 1 байраар урагшилсан байна.

ҮСХ-ны [www.nso.mn](http://www.nso.mn), статистикийн мэдээллийн нэгдсэн сан буюу [www.1212.mn](http://www.1212.mn) сайтуудын агуулга, контентуудыг нэгтгэн хэрэглэгч ашиглахад хялбар байхаар шинэчлэн хөгжүүлсэн байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн санг тооллого, судалгаа, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга, статистикийн эмхэтгэл, хүн ам, нийгэм эдийн засгийн салбарын танилцуулга, судалгаа, шинжилгээний тайлан, бусад мэдээллээр тухай бүр баяжуулж, мэдээлэл хүссэн гаднын болон дотоодын байгууллага, иргэдэд холбогдох мэдээллийг хүргүүлж ажилласан байна.

Мөн судалгааны задгай дата мэдээллийн нууцлалыг ханган статистикийн мэдээллийн нэгдсэн санд байршуулж хэрэглэгч судалгаа, шинжилгээ хийх боломжийг бүрдүүлжээ.

2022 онд 56 видео контент, 420 постер инфографик бэлтгэж сошиал сувгуудаар хэрэглэгчдэд тархааж, 12 удаагийн хэвлэлийн бага хурал, хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийг сайжруулах зорилгоор 3 удаагийн хэлэлцүүлэг, төрийн байгууллагын албан хаагчдад 12 удаагийн сургалтыг зохион байгуулжээ.

Монгол Улсын статистикийн 2021 оны эмхэтгэлийг хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны үзүүлэлт бүхий 25 бүлгийн мэдээллийг 5 жилээр, Үндсэн хуулийн 30 жилийн ойд зориулан зургийн цомог бүхий статистикийн эмхэтгэлийг 1989-2020 оноор бэлтгэж тус тус тархаасан байна.

Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх

боломжийг судлан эхний төслийг боловсруулсан байна. Тус хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг эцэслэн хууль санаачлагчид өргөн барьж шийдвэрлүүлснээр албан ёсны статистикийн үндсэн зарчмууд хангагдаж, статистикийн байгууллагын үйл ажиллагаа, статистикийн мэдээллийн хүрээ, чанар улам сайжрах боломжууд нэмэгдэх юм.

Статистикийн байгууллага үйл ажиллагаагаа улам сайжруулах, туршлага судлах, хүний нөөцөө хөгжүүлэх, сургаж бэлтгэхэд бусад улс орнуудын статистикийн байгууллагуудтай хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. ҮСХ-ны хувьд олон талт болон хоёрт талт хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан байна. Тухайлбал, хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 14 орны статистикийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

ҮСХ-ны дарга “Ази, Америк, Номхон далайн орнуудын үндэсний тооллого, статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэг”-ийн дэд ерөнхийлөгчөөр 2022-2024 онуудад ажиллахаар сонгогдож, хүн амын тооллогын 32 дугаар бага хурлыг 2024 онд Улаанбаатар хотод зохион байгуулахаар болжээ. Мөн НҮБ-ын Хүн амын сангаас улс орныг дэмжих 5 жилийн хугацаатай “7 дугаар хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан байна.

ҮСХ нь мэргэжлийн байгууллагын хувьд Статистикийн тухай болон бусад холбогдох хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэх, статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх, судалгаа шинжилгээ хийх, үйл ажиллагаагаа улам сайжруулахад хүний нөөцийн чадавх, туршлага, мэргэшсэн ажилтны тогтвор суурьшил чухал үүрэгтэй.

ҮСХ-ны зүгээс салбарын албан хаагчдынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, шинэ мэдээлэл олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 623 албан хаагчийг хамруулжээ.

Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулсан 61 цахим болон танхимын сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 113 албан хаагчийг хамруулжээ.

Мөн салбарын хүний нөөцийг бэлтгэхэд анхаарч ҮСХ-ны газар, хэлтсүүдэд статистик, эдийн засаг, мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байгаа 70 оюутныг мэргэжлийн чиглэлээр нь дадлагажуулсан байна.

ҮСХ, аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст 8 удаагийн тусгай шалгалтаар 74 сул орон тоог нөхсөн байна. Үүнээс харахад жилийн дотор ҮСХ-ны төв, орон нутгийн хүний нөөцийн 23.1 хувьд өөрчлөлт хөдөлгөөн орсон нь албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

Төрийн болон албаны нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, шинээр ажилд орсон албан хаагчдад нууц мэдээлэлтэй хэрхэн ажиллах талаар мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр ҮСХ-ноос 1 удаагийн сургалт, Тагнуулын ерөнхий газартай хамтран 1 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт албан хаагчдаа хамруулсан байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн 2022 оны гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнг, мэргэжлийн түшинг үнэлэх журам”-д заасны дагуу ҮСХ-ны даргын 2022 оны А/207 дугаар тушаалаар төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээний багийг байгуулж, үнэлсэн байна.

ҮСХ нь аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн ажлын үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн баталсан байна. Шинэчилсэн журмын дагуу тухайн шалгуур үзүүлэлтэд заасан ажлын үр дүн гарах хугацаанаас хамааруулан үнэлгээг сар, улирал, хагас жил, жилээр гаргаж, тухай бүр ҮСХ-ны удирдлага болон орон нутгийн статистикийн газар, хэлтсийн дарга нарт танилцуулжээ. Ингэснээр орон нутгийн статистикийн газар, хэлтсийн дарга нар тухайн оны ажлаа жилийн эцэст үнэлүүлж, үнэлгээтэйгээ танилцдаг байсан бол 2022 оноос сар, улирал, хагас жил, жилээр үнэлгээ гарсан тухай бүрт танилцаж, алдаа дутагдлаа засах, ажлын зохион байгуулалт, гүйцэтгэл, үр дүнгээ сайжруулах боломжийг бүрдүүлсэн байна.

## 1.2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа

ҮСХ нь Төсвийн тухай болон бусад холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд төсөв санхүүгийн үйл ажиллагааг явуулах, аливаа зөрчил гаргахгүй байх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ.

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 “Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төсөв нь статистикийн үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

Статистикийн үйл ажиллагааг сум, баг, хороонд эрхлэн явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу Статистикийн байгууллагын 2022 төсвийг 17.8 тэрбум төгрөгөөр баталж, 3 удаагийн тодотголоор 16.1 тэрбум төгрөг болгон бууруулжээ.

Сангийн яамнаас төсвийг хянахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 “Энэ хуулийн 15.1.4<sup>6</sup>, 15.2.3<sup>7</sup>-т заасан арга хэмжээ нь байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотой бол тэдгээр арга хэмжээг хэмнэлтийн горимд хамааруулахгүй байж болно” заалтыг хэрэгжүүлэхгүй байгаагаас тооллого, судалгаануудын сургалт, семинарын болон хяналтын зардлууд батлагдахгүй байна.

Мөн хуулийн дагуу тодорхой давтамжтай зохион байгуулдаг судалгааны хувьд төсөв танагдсанаас тус тооллогод ажиллах судлаачийн цалинг бууруулснаар

<sup>6</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;

<sup>7</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилго болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

судалгаа авах хүний нөөцийн асуудал тулгарсан. Эдгээр нь мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болгосныг ҮСХ-ны газар, нэгжүүдээс зарим судалгаанд хийсэн хяналт шалгалт, 3 аймгийн статистикийн хэлтэст хийсэн дотоод аудитын тайлангаас харагдаж байна.

ҮСХ-оос Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа жил бүрийн инфляцын түвшинг тооцож Сангийн яаманд хүргүүлж байгаа боловч тухайн жилийн төсвийн хязгаарыг хянахдаа өмнөх жилийн төсвийн төсвөөс нэмэгдүүлэхгүйгээр баталж байгаа нь шатахууны үнийн өсөлт, судалгаанд хамрагдах малчин өрхүүд отор нүүдлээр явсан байх, түүвэрт хамрагдах өрхийн тоо нэмэгдэх зэргээс шалтгаалж төсөвлөсөн шатахуун хүрэлцэхгүй байх, судалгаагаа авч чадахгүй болох эрсдэл бий болгож байна.

Тус оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулахад 5.0 тэрбум буюу 45.6 хувиар нэмэгдсэн байна. Үүний 2.6 тэрбум (52.2 хувь) төгрөг нь Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.л-д заасан 10 жил тутам зохион байгуулах хөдөө аж ахуйн ээлжит тооллогын зардал, 2.1 тэрбум (42.0 хувь) төгрөг нь хөрөнгийн зардал байна.

Статистикийн байгууллагын нийт төсвийн 34.3 хувийг тооллого, судалгааны зардал, 44.1 хувийг цалингийн зардал, 4.0 хувийг байр ашиглалтын зардал, 1.1 хувийг холбооны суваг ашигласны хөлс, 3.3 хувийг бусад зардал, 13.2 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

#### ХҮСНЭГТ 18. 2022 ОНЫ ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ<sup>8</sup>

№	Зардал	Санхүүжилт сая.төг	Зарцуулалт сая.төг	Хэмнэлт сая.төг
	<b>Нийт</b>	<b>16 133.4</b>	<b>15 835.2</b>	<b>298.2</b>
1.	Тооллого, судалгааны зардал	5 530.3	5 528.1	2.3
2.	Цалингийн зардал	7 109.2	6 839.0	270.2
3.	Байр ашиглалтын зардал	652.9	652.9	-
4.	Холбооны суваг ашигласны хөлс	174.9	174.9	-
5.	Бусад зардал	537.9	512.2	25.7
6.	Хөрөнгийн зардал	2 128.2	2 128.2	-

Төсвийн зарцуулалтаас харахад хэмнэгдсэн зардлын 90.6 хувийг цалингийн зардал эзэлж байна. Үүнээс 158.2 сая төгрөг нь ҮСХ-ноос, 112.0 сая төгрөг нь аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсийн цалингийн зардлаас хэмнэгджээ. Энэ нь 2022 онд хүний нөөцийн хөдөлгөөн их байснаас шалтгаалсан байна.

ҮСХ-ны хувьд хөрөнгийн зардал 2014-2019, 2021 онуудад батлагдаагүй байна. 2022 оны батлагдсан хөрөнгийн зардлаар салбарын хэмжээнд шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлыг хангах программ хангамжийн лиценз, машин, тоног төхөөрөмж, тавилдаг худалдан авч хуваарийн дагуу харьяа нэгжүүдээс шилжүүлж

<sup>8</sup> Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэдээлэлд үндэслэв.

статистикийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, ажилтнуудыг ажиллах боломж, нөхцөлийг сайжруулжээ.

2022 оны хөрөнгө оруулалтын зардлаас тооллого, судалгааг төлөвлөсөн хугацаанд чанартай зохион байгуулах, орон нутгийн статистикийн хэлтсүүдэд үүсэж байгаа хүндрэл бэрхшээл, тэдний санал хүсэлтийг шийдвэрлэх, ажиллаж буй судлаачдын аюулгүй байдлыг хангах хүрээнд 12 аймгийн статистикийн хэлтэст тусгай тоноглол бүхий автомашиныг худалдан авч олгожээ. Мөн ҮСХ-ны 2 автомашин, 20 аймгийн статистикийн хэлтсийн автомашинд GPS төхөөрөмжийг суулгаж, хяналт тавьж эхэлсэн байна. Энэ нь салбарын хэмжээнд аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, автомашины хурд, судлаачдын аюулгүй байдал, явсан зай, шатахууны зарцуулалт, томилолтын зардал, судлаачийн 1 өрхөөс судалгаа авах дундаж хугацааг судалгаа авсан хугацаатай харьцуулж, судалгааны хяналтыг сайжруулах боломжуудыг бүрдүүлжээ.

ҮСХ хороо нь төсвийн шууд захирагчдаас төсвийн холбогдох мэдээ, тайланг тухай бүр авч нэгтгэн тогтоосон хугацаанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажилласан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 21 аймаг, нийслэлийн төсвийн шууд захирагч нарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд хийсэн санхүүгийн аудитаар “Зөрчилгүй” санал, дүгнэлт авсан байна. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал, дүгнэлтийг өгчээ.

ҮСХ-ны зүгээс 2022 онд Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай болон бусад хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэх, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг улам сайжруулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр харьяа төсвийн шууд захирагч нарт заавар, үүрэг, чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ. Үүнд:

- ✓ Төрийн аудитын байгууллагаас төсвийн шууд захирагч нарын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 41 зөвлөмж;
- ✓ ҮСХ-ны даргаас харьяа төсвийн шууд захирагч нарт төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтийн горимд баримтлах чиглэл, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, ил тод байдлыг хангах, өр, авлага үүсгэхгүй байх, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах талаар 3 заалтын хүрээнд 30 чиглэл, үүрэг;
- ✓ Төсвийн 21 шууд захирагчийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд явагдаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, гарсан алдаа зөрчлийг засаж, залруулах зорилго бүхий санхүүгийн дотоод аудитыг хийж, төсвийн шууд захирагч бүрд дүгнэлт гарган, давхардсан тоогоор 300 зөвлөмж;

✓ Төсвийн шууд захирагч нарын 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн шилэн дансны мэдээлэл байршуулалтад нийцлийн дотоод аудит хийж, төсвийн шууд захирагч нарт давхардсан тоогоор 128 зөвлөмж;

✓ Төсвийн шууд захирагч нарын 2021 оны жилийн эцсийн худалдан авах үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөрчлийг давтан гаргахгүй байхад чиглэсэн 9 зөвлөмж хүргүүлсэн.

Тухайлбал дараах үр дүнд хүрсэн байна:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, заавар, зөвлөмж хүргүүлж ажилласны үр дүнд 2016 онтой харьцуулахад шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээллийн хугацаа хоцролт 37.1 хувиар буурч 2022 онд 0.4 хувь, мэдээлсэн байдал 51.3 хувиар өсөж 2022 онд 99.8 хувь болсон байна. Дэлгэрэнгүйг зураг 1-т харуулав.

ЗУРАГ 29. ШИЛЭН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТ, жилээр



2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд гарсан залруулагдаагүй алдаа, зөрчлийн мөнгөн дүн өмнөх оноос 2 дахин буурсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулав.

ХҮСНЭГТ 19. 2020, 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ГАРСАН ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Үзүүлэлт	2020 он		2021 он	
	тоо	мөнгөн дүн, сая.төг	тоо	мөнгөн дүн, сая.төг
Нийт дүн	46	151.2	25	78.4
Зөвлөмж	29	108.1	19	58.8
Акт	6	2.3	1	0.4
Албан шаардлага	13	40.8	5	19.2

ҮСХ-ны зүгээс төсвийн шууд захирагч нарын төсөв, санхүү, шилэн дансны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, заавар зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласны үр дүнд төсөв, санхүү, шилэн дансны үйл ажиллагаа сайжирч байгаа хэдий ч нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэж буй ажилтнуудын хөдөлгөөн их байгаагаас шалтгаалан зарим алдаа, зөрчил арилахгүй байна. Тухайлбал, 21 аймгийн статистикийн хэлтсийн хувьд 2016 оноос хойш 55 (2016 онд 4, 2017 онд 6,

2018 онд 10, 2019 онд 9, 2020 онд 12, 2021 онд 6, 2022 онд 8) нягтлан бодогч, ҮСХ-ны хувьд 2022 онд 2 нягтлан бодогч өөрчлөгдсөн байна.

ҮСХ нь тооллого, судалгааны мэдээлэл цуглуулалтад таблет ашигласнаар цаасны зарцуулалтыг эрс багасгаснаас гадна мэдээллийг шивэх, цуглуулах, боловсруулахад зарцуулах хугацаа, зардлыг хэмнэж, цуглуулсан мэдээллийг тухай бүр дамжуулах боломжийг бүрдүүлэн ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

ҮСХ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дотоод үйл ажиллагаагаа цахимжуулах, зарим хэвлэмэл бүтээгдэхүүн, гарын авлагын хэвлэх тоог бууруулах зэргээр 16.1 сая төгрөгийн зардлыг хэмнэжээ. Тухайлбал:

- ✓ Дотоод үйл ажиллагаагаа цахимжуулах, баримт бичгийг цахимаар хянах ажлыг шат дараатай хэрэгжүүлжээ. Тухайлбал, санхүүжүүлэгч орны зардлаар гадаад сургалтад нэр дэвшүүлэх албан хаагчийн саналыг 01 дүгээр сараас, статистикийн сарын танилцуулга болон бусад мэдээллийг 02 дугаар сараас, албан бичиг, тушаалын төслийг 04 дүгээр сараас, албан хаагчдын чөлөө авах хүсэлт болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг 10 дугаар сараас тус тус цахимаар хянаж эхэлсэн байна. Байнга давтагддаг процессыг цахимд шилжүүлснээр баримт бичиг боловсруулж, хянуулж буй албан хаагчдын цагийг хэмнэж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, нөгөө талаас зардал хэмнэх чухал ажил болжээ. Баримт бичгүүдийг цахимд шилжүүлсэн хугацаанаас хойш тооцоход 2022 онд 108 боодол цаас, 27 принтерийн хор хэмнэж, нийт 2.8 сая төгрөг;
- ✓ ҮСХ-оос хэвлэх цехийн ачааллыг тэгш хуваарилах, шаардлагатай материалын бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 2022 онд хэвлэх цехээр гүйцэтгүүлэх захиалгыг баталсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус захиалгад туссан зарим салбарын танилцуулга, тайлан, гарын авлагын хэвлэх тоо ширхгийг бууруулж цахимаар тархааснаар 1.8 сая төгрөг;
- ✓ Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдлын сарын танилцуулгын хэвлэх тоог 2021 оноос 3 дахин бууруулж цахимаар тархааснаар 11.6 сая төгрөгийг хэмнэсэн байна. Тооцоог хавсаргав.

ҮСХ-ны зүгээс төсвийн шууд захирагч нарын 2022 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж, үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласны үр дүнд ҮСХ-ны даргын төсвийн багцад хамаарах 21 аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрууд нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа төрийн аудитын байгууллагын харьяа аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлж, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

ҮСХ нь төсвийн шууд захирагчийн хувьд 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуульд заасан хугацаанд төрийн аудитын төв байгууллагад хүргүүлсэн. Мөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн

8.9.5-д зааснаар ҮСХ нь төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 23 төсвийн шууд захирагчдын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хуулийн хугацаанд буюу 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна.

## ДҮГНЭЛТ

1. ҮСХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд олон улсын статистикийн байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартын дагуу бодит байдалд нийцсэн чанартай, албан ёсны статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна.
2. Олон улсын стандартад нийцүүлэн статистикийн аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо, хүртээмж нэмэгдсэн байна.
3. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг боловсруулж, батлан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгосон;
4. Анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах 5 багц журмыг шинэчлэн баталж, мөрдөж эхэлсэн.
5. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын мэдээлэл цуглуулалтыг таблет ашиглан газар зүйн мэдээллийн системтэй уялдуулан зохион байгуулж, өндөр нарийвчлалтай сансрын зургийн мэдээллээр тариалангийн талбайн байршил, өрх, ААНБ-ын байршлын цэгийг тэмдэглэсэн байна.
6. “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдөл” төслийг Азийн хөгжлийн банкны 1.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр болж, санамж бичгийг байгуулсан байна.
7. Төрийн байгууллагуудтай хамтран “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл журам”, “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан Засгийн газрын тогтоолоор батлуулсан.
8. “Статистикийн үйл ажиллагаанд хамаарах нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын тайлбарыг боловсруулж, ҮСХ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар баталсан.
9. Дотоод үйл ажиллагаа, тооллого, судалгааг цахимжуулж зардал хэмнэсэн;
10. Сангийн яамнаас тухайн жилийн төсвийн хязгаарыг хянахдаа өмнөх жилийн төсвийн төсвөөс нэмэгдүүлэхгүйгээр баталж байгаа нь шатахууны үнийн өсөлт, судалгаанд хамрагдах малчин өрхүүд отор нүүдлээр явсан байх, түүвэрт хамрагдах өрхийн тоо нэмэгдэх зэргээс шалтгаалж төсөвлөсөн шатахуун хүрэлцэхгүй байх, судалгаагаа авч чадахгүй болох эрсдэл бий болгож байна.

## САНАЛ

1. Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлэх;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан ажлыг бүрэн гүйцэтгэхэд анхаарч ажиллах;

Системчилсэн үнэлгээний тайлангийн хавсралт 1

**ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1.1 ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛСНААР ХЭМНЭСЭН ЦААС**

№	Баримт бичгийн төрөл	Цахимд шилжсэн сар	Цахим шилжүүлснээр хэмнэсэн цаас	
			ширхэг	боодол
<b>Нийт</b>			<b>53 971</b>	<b>108</b>
1.	Албан бичгийн төсөл, хавсралт	04	4 455	8.9
2.	А тушаалын төсөл, хавсралт	04	2 879	5.8
3.	Б тушаалын төсөл, хавсралт	04	330	0.7
4.	Даргын зөвлөлийн 5 удаагийн хурлаар хэлэлцүүлэх, танилцуулах материал	10	21 738	43.5
5.	Албан хаагчдын чөлөө авах хүсэлт	10	16	0
6.	Гадаад сургалт, арга хэмжээнд нэр дэвшүүлэх санал, хавсралт	01	268	0.5
7.	Статистикийн 1-11 сарын танилцуулгын мэдээллийг хянах	02	10 330	20.7
8.	Статистикийн эмхэтгэлийн мэдээлэл	04	13 955	27.9

**ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1.2 ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ, ХЭМНЭСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Үзүүлэлт	Цаас			Принтерийн хор			Нийт
		боодол	дундаж үнэ	нийт	ширхэг	дундаж үнэ	нийт	
			мян.төг			мян.төг		
<b>Дүн</b>								<b>16 148.4</b>
1	Дотоод үйл ажиллагааг цахимжуулснаар хэмнэсэн зардал /хар хор/ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн сарын танилцуулгын хэвлэх хувийг 3 дахин	108	14.8	1 597.5	27	43.7	1 179.9	2 777.4
2	бууруулснаар хэмнэсэн зардал /өнгөт хор/ Хэвлэх цехийн 2022 оны захиалгад туссан зарим салбарын танилцуулга, тайлан, гарын авлагын хэвлэх тоог бууруулснаар	561	14.8	8 302.8	8	480.3	3 266.4	11 568.8
3								1 802.2

## ХАВРАЛТ

### ХАВСРАЛТ 1. ҮСХ-НООС ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛЖ МӨРДҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР

№	Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр	Тайлбар
<b>А. Аргачлал</b>		
1	БОЭЗДС-ийн ХАА-н данс байгуулах аргачлал	Шинэ
2	Орон сууцны үнийн индексийг хедоник регрессийн аргаар тооцох аргачлал	Шинэчилсэн
3	Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал	Шинэчилсэн
4	Орлого орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал	Шинэчилсэн
5	Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал, маягт, каталог	Шинэчилсэн
6	Эрчим хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлал	Шинэчилсэн
7	Хөдөө аж ахуйн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал	Шинэчилсэн
<b>Б. Ангилал</b>		
1	Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, тайлбар	Шинэ
<b>В. Үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх заавар</b>		
1	Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааны асуулга, заавар, үзэл баримтлал	
2	Хүн амын богино хугацааны тандалтын судалгааны маягт, нөхөх заавар	
3	Хөдөө аж ахуйн тооллогын үзэл баримтлал, асуулгын хуудас, нөхөх заавар	
4	Хүн амын дотоод шилжилтийн хөдөөгөөс хот руу чиглэсэн хөдөлгөөн түүвэр судалгааны аргачлал, маягт, нөхөх заавар	
5	Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгийн дотоод шилжих хөдөлгөөний түүвэр судалгааны аргачлал, маягт, нөхөх заавар;	
6	Мал, махны үйлдвэрлэгчийн үнэ, борлуулалтын туршилтын судалгааны үзэл баримтлал	
7	Тогтвортой хөгжлийн зорилгын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг тооцоход ашиглагдах мэдээллийг Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд суурилан цуглуулж, үзүүлэлтийг туршилтаар тооцох судалгааны үзэл баримтлал	
8	Цаг ашиглалтын судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх заавар	
9	ӨНЭЗС, АХС болон Ногоон ажлын байрны судалгааны маягт, нөхөх заавар	
10	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын тайлангийн маягт	
11	Эрүүл мэндийн даатгалын албан ёсны болон захиргааны маягт, нөхөх заавар	
12	ЖЭТБХ талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн маягт, нөхөх заавар	
13	<b>Залуучуудын захиргааны статистикийн маягт, нөхөх заавар</b>	
14	Бүрэн дунд боловсролын салбарын маягт, нөхөх заавар	
15	Сонгуулийн статистикийн маягт, нөхөх заавар	

№	Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр	Тайлбар
<b>Г Тооцоо, тооцоолол</b>		
1	Хэрэглээний үнийн индексийн суурь, сагс, жинг шинэчлэх тооцоолол	Шинэчилсэн
2	Хүн амын амьжиргааны доод түвшний 2022 онд мөрдөх тооцоо	Шинэчилсэн
<b>Д Түүвэр судалгаа</b>		
1	Хагас жилийн малын түүвэр судалгаа	
2	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	
3	Ажиллах хүчний болон албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	
4	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	
5	Ардчилсан засаглал судалгаа	
6	Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа	
7	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (нэмэх)	
8	Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа	
9	ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг туршилтаар тооцох түүвэр судалгаа	
<b>Г Судалгаа</b>		
1	Хүн амын богино хугацааны шилжих хөдөлгөөний судалгаа	
2	Мах, махны үйлдвэрлэлийн үнэ, борлуулалтын судалгаа	
3	Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах” туршилтын судалгаа	
4	“Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжих хөдөлгөөн”-ий туршилтын судалгаа	

## ХАВСРАЛТ 2. ҮСХ-НООС 2022 ОНД ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН ДЭЛХИЙН ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Код	Мэдээллийн эх үүсвэрийг сайжруулан боловсруулсан үзүүлэлт	Тайлбар
1	16.7.2	Шийдвэр гаргалт нь олон нийтийн оролцоотой, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт итгэдэг хүн амын хувь	Ардчилсан засаглал судалгааны маягтад шинэчлэгдсэн аргачлалын дагуу оруулсан.
2	5.а.1	Хөдөө аж ахуй эрхлэгчдэд хөдөө аж ахуйн газар эзэмших хууль ёсны эрхтэй хүн амын эзлэх хувь, хүйсээр, б) ХАА-н газар эзэмших хууль ёсны эрхтэй хүмүүсийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, газар эзэмших эрхийн хэлбэрээр 1 ажилтанд ногдох бүтээгдэхүүн	Хөдөө аж ахуйн тооллогын үзэл баримтлал, асуулгын хуудаст тогтвортой хөгжлийн зорилгын 5.а.1, 2.3.1 үзүүлэлтүүдийг тооцох мэдээллийн эх үүсвэрийг болон 2.1.1, 2.4.1, 12.3.1 үзүүлэлтийг
3	2.3.1	үйлдвэрлэлийн хэмжээ, фермийн/ойн/бэлчээрийн мал аж ахуйн нэгжийн хэмжээгээр	тооцоход ашиглагдах боломжит зарим
4	2.1.1	Хоол тэжээлийн дутагдлын тархалт	мэдээллийн эх үүсвэр

5 2.4.1 Бүтээмжтэй, тогтвортой хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагддаг хөдөө аж ахуйн газар нутгийн эзлэх хувь (бүрэн бус)-ийг бий болгохоор асуултуудыг оруулж өгсөн.

6 12.3.1 Дэлхийн хүнсний алдагдлын индекс

**Сайжруулсан үзүүлэлт**

1 5.1.1 Хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдлыг цогцлоох, хангах, үнэлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх Орлуулах үзүүлэлтээр тооцож байсныг АХБ-ны төслөөр аргачлалын дагуу сайжруулан тооцсон.

2 5.a.2 Эмэгтэйчүүдийн газар эзэмших, захиран зарцуулах тэгш эрхийг баталгаажуулсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх Орлуулах үзүүлэлтээр тооцож байсныг АХБ-ны төслөөр аргачлалын дагуу сайжруулан тооцсон.

3 12.6.1 Тогтвортой байдлын тайланг хэвлэдэг компаниудын тоо “Нийт аж ахуйн нэгжид байгаль орчны удирдлагын ISO-14001 стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн эзлэх хувь” гэсэн орлуулах үзүүлэлтээр тооцож байсныг АНН тооллогын асуулгад холбогдох асуултыг нэмэн мэдээллийг цуглуулж, тооцсон. Мэдээллийн чанар сайжирсан. Хэдийгээр АНН тооллогын маягтад “Тогтвортой байдлын тайланг хэвлэдэг компаниудын тоо” -г гаргах асуултыг оруулж мэдээллийг цуглуулсан боловч үр дүнг ашиглах боломжгүй, бодит бус тоо гарсан. Мэдээлэгчийн ойлголт буруугаас буруу мэдээлэл өгсөн гэж үзсэн.

4 16.7.1.c Шүүхийн албан хаагчдын эзлэх хувь, шүүхийн ангиллаар, хүйсээр, насны ангилал, хөгжлийн бэрхшээлээр Тоо мэдээллийг 2015-2021 оны байдлаар ШЕЗ-өөс авч, үзүүлэлтийг туршилтаар тооцсон. ШЕЗ-өөс ирүүлсэн тоо мэдээлэл нь зөрүүтэй байгаа тул үзүүлэлтийн мэдээллийг

			тархаах боломжгүй. 2023 онд ШЕЗ-өөс мэдээллийг зөв гаргаж өгөхийг хүсэх шаардлагатай. туршилтаар/
<b>Шинээр нэмж тооцсон үзүүлэлт</b>			
1	5.c.1	Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор төсөв хуваарилах, хянах тогтолцоотой эсэх	АХБ-ны төслөөр аргачлалын дагуу шинээр тооцсон.
2	5.6.2	15, түүнээс дээш насны эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, мэдээлэл, боловсролыг бүрэн, тэгш хүртээмжтэй авах эрхийг баталгаажуулсан хууль тогтоомж, дүрэм, журамтай эсэх	АХБ-ны төслөөр аргачлалын дагуу шинээр тооцсон.
3	9.b.1	Боловсруулах салбарын нийт нэмэгдэл өртөгт дунд болон өндөр технологитой үйлдвэрийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь	Үзүүлэлтийг 2015-2021 оноор шинээр тооцсон.
4	4.1.2	Сургууль төгсөлтийн түвшин	Үзүүлэлтийг НҮТС-аас 2018 оноор тооцуулсан. Гэхдээ ӨНЭЗС, ХАӨМС-гийн мэдээллээр давхар тооцож харьцуулж сонгох шаардлагатай.
5	2.2.3	15-49 насны эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалт	"Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь" гэсэн үзүүлэлтээр орлуулж шинээр тооцсон.
6	16.3.2	Сэжигтнээр татагдсан хүний нийт хоригдлын тоонд эзлэх хувь	Тоо мэдээллийг 2015-2021 оны байдлаар ШЕЗ-өөс авч, үзүүлэлтийг туршилтаар тооцсон. ШЕЗ-өөс ирүүлсэн тоо мэдээлэл нь зөрүүтэй байгаа тул үзүүлэлтийн мэдээллийг тархаах боломжгүй. 2023 онд ШШГЕГ-аас мэдээлэл хүсэх шаардлагатай.

**ХАВСРАЛТ 3. ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Зорилго	НҮБ-аас баталсан үзүүлэлт тоо	Тооцох боломжгүй байгаа үзүүлэлт	Мөнгөл Улсад хамааралгүй	Үндэсний түвшинд батлагдсан аргачлалтай үзүүлэлтүүд	Мөнгөл Улсад тооцож байгаа
Зорилго 1: Ядуурлыг устгах	13	5	-	7	8
Зорилго 2: Өлсгөлөнг зогсоох	14	6	-	7	8
Зорилго 3: Эрүүл мэндийг дэмжих	28	9	2	24	17
Зорилго 4: Чанартай боловсролыг дэмжих	12	2	-	9	10
Зорилго 5: Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	14	2	1	9	11
Зорилго 6: Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	11	5	-	7	6
Зорилго 7: Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	6	1	-	5	5
Зорилго 8: Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	16	2	-	14	14
Зорилго 9: Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	12	5	-	9	7
Зорилго 10: Тэгш бус байдлыг бууруулах	14	9	-	5	5
Зорилго 11: Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	14	7	-	7	7
Зорилго 12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих	13	10	-	5	3
Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	8	4	-	3	4
Зорилго 14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	-	10	0	0
Зорилго 15: Хуурай газрын эко системийг хамгаалах	14	9	-	5	5
Зорилго 16: Энх тайван, шударга ёсыг цогцлоох	24	7	-	17	17

Зорилго 17: Хөгжлийн төлөөх түншлэлийг бэжжүүлэх	24	14	-	11	10
<b>Нийт</b>	<b>247</b>	<b>97</b>	<b>13</b>	<b>144</b>	<b>137</b>

#### ХАВСРАЛТ 4. ҮСХ-НООС 2022 ОНЫ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ, ТАНИЛЦУУЛГА

№	Шинжилгээ, судалгааны ажил
1	Монгол Улсын ядуурлын шилжилт
2	Агаарын бохирдлын хөдөлмөрийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөөллийн судалгаа
3	Эдийн засгийн бүсчилсэн хөгжил ба дотоод шилжих хөдөлгөөний хамаарлын шинжилгээ
4	Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор
5	Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, төрийн бодлого, шийдвэрт ашиглах нь: Кейс шинжилгээ
6	"Монгол Улсын эдийн засгийн өсөлт ба хүн амын өсөлтийн хамаарлыг ARDL загвараар үнэлэх нь" судалгаа
7	"Сурагчдын гэр, сургуулийн байршлыг тодорхойлох, сургуулийн зай, замын түгжрэлийн хамаарлыг гаргах" судалгаа
8	"Цар тахал ба ЕБС-ийн сургалтын чанарын хамаарлыг гаргах" судалгаа
9	Монгол Улсын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн байдал
10	Эдийн засгийн аюулгүй байдал
11	Төсвийн хэмнэлт эдийн засагт хэрхэн нөлөөлөх тооцоолол, танилцуулга
12	Инновацын ААН-ийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ

#### ТАРХААСАН САРЫН ТАНИЛЦУУЛГУУД

№	Танилцуулгын нэр	Танилцуулга тоо	Хугацаа
1	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2021 XII	26	2022 оны 01 сарын 16
2	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 I	18	2022 оны 02 сарын 17
3	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 II	14	2022 оны 03 сарын 16
4	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 III	19	2022 оны 04 сарын 15
5	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 IV	20	2022 оны 05 сарын 17
6	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 V	16	2022 оны 06 сарын 16
7	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 VI	22	2022 оны 07 сарын 19
8	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 VII	19	2022 оны 08 сарын 17
9	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 VIII	11	2022 оны 09 сарын 16
10	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 IX	16	2022 оны 10 сарын 16

11	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 X	15	2022 оны 11 сарын 17
12	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2022 XI	8	2022 оны 12 сарын 16

#### САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГУУД

№	Танилцуулгын нэр
1	Бүс нутгийн ДНБ, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал – 2021 онд
2	ДНБ, хөдөлмөрийн бүтээмж – 2021 онд (монгол, англи хэлээр)
3	Үндэсний тооцооны урсгал данс, нийгмийн тооцооны матриц – 2021 онд
4	Үндэсний тооцооны хуримтлалын данс, актив-пассивын данс – 2021 онд
5	ЖДҮ-ийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр – 2021 онд
6	Үндэсний тооцоо – 2021 онд
7	Хөрөнгө оруулалт – 2021 онд (монгол, англи хэлээр)
8	Материалын урсгалын данс – 2021 онд
9	Агаар дахь ялгаруулалтын данс – 2021 онд
10	Хатуу хог хаягдлын данс – 2021 онд
11	Эрчим хүчний биет урсгалын данс – 2021 онд
12	Усны биет урсгалын данс – 2021 онд
13	Байгаль орчны татварын данс – 2021 онд
14	Газар ашиглалтын данс – 2021 онд
15	Байгаль орчин-эдийн засгийн дансны систем – 2021 онд
16	Тээврийн салбар – 2021 онд
17	Хөдөө аж ахуйн салбар – 2021 онд
18	Барилгын салбар – 2021 онд
19	Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд – 2021 онд
20	Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан – 2021 он
21	Хүн ам – 2021 онд
22	Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмчийн салбар – 2021 онд
23	ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин – 2021 онд
24	Аж үйлдвэрийн салбар – 2021 онд
25	Хөдөлмөрийн салбар – 2021 онд
26	Гадаад худалдаа – 2021 онд
27	Статистикийн бизнес регистр – 2021 онд
28	Эрүүл мэндийн салбар – 2021 онд
29	Нийгмийн даатгал, халамж – 2021 онд
30	Гэмт хэрэг – 2021 онд
31	Аж үйлдвэр, үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн индекс – 2021 онд
32	Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид – 2021 онд
33	Төрийн санхүү, өрийн статистик – 2021 онд
34	Статистикийн бизнес регистр – 2021 онд
35	Хэрэглээний үнэ – 2021 онд
35	Бүс нутгийн ДНБ, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал – 2021 онд

**ХАВСРАЛТ 5. ҮСХ-НООС 2022 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, зорилтот бүлгээр**

№	Сургалтын сэдэв	Хамрагдсан		Хүний тоо
		Байгууллагын нэр		
<b>A</b>	<b>Хэрэглэгчдэд</b>			<b>353</b>
1	Статистикийн мэдээллийн нэгдсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын сангийн хэрэглээ, ашиглалт		хөгжлийн газар	56
2	Статистикийн мэдээллийн нэгдсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын сангийн хэрэглээ, ашиглалт		хөгжлийн газар	30
3	Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргазүй, прогноз хийх тухай	Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн урсгал, төлөвлөлтийн алба		10
4	Статистикийн мэдээллийн нэгдсэн Соёлын яамны нийт албан сангийн хэрэглээ, ашиглалт	хаагчид		60
5	Барилгын салбарын мэдээний нэгдсэн Барилгын харилцаа, барилга, хот программн заавар, анхаарах асуудал	байгуулалтын газар, Барилгын хөгжлийн төв		13 5
6	Статистикийн мэдээллийн нэгдсэн Тээврийн цагдаагийн алба сангийн хэрэглээ, ашиглалт			15
7	Статистикийн мэдээллийн нэгдсэн Монголын Үндэсний Худалдаа, сангийн хэрэглээ, ашиглалт	Аж Үйлдвэрийн Танхим		30
8	Статистикийн танилцуулга бэлтгэх Сангийн яам, Хөгжлийн банк, заавар	Төрийн банк		17
<b>B</b>	<b>Судалгааны мэдээлэл цуглуулагч нар</b>			<b>130</b>
1	Статистикийн үзүүлэлтийн арга зүй, аргачлал	ӨНЭЗС-АХС-ны цуглуулагч нар	мэдээлэл	65
2	Манлайлал ба багаар үр дүнтэй хамтран ажиллах нь	ӨНЭЗС-АХС-ны цуглуулагч нар	мэдээлэл	65
<b>B</b>	<b>Статистикийн ажилтнуудад</b>			<b>623</b>
1	Статистикийн арга зүй			126
2	Tableau Desktop I, II, III шатны сургалт			22
3	Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн систем (SPS)-ийн I, II шатны сургалт			22
4	Adobe In Design программын анхан шатны сургалт			49
5	Adobe Illustrator CS программыг ашиглан инфографик зурах			76
6	Stata программын сургалт			20
7	R программын сургалт			20
8	SQL программчлалын хэл			15
9	Англи хэлний анхан шатны сургалт			43
10	Англи хэлний дунд шатны сургалт			30
11	Англи хэлний ахисан дунд шатны сургалт			34
12	Англи хэлээр албан и-мэйл бичих сургалт			74
13	Шинэ албан хаагчдын сургалт			14
14	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт			78

№	Сургалтын сэдэв	Хамрагдсан	
		Байгууллагын нэр	Хүний тоо
	Нийт дүн		1106

**ХАВСРАЛТ 6. ҮСХ-НООС 2022 ОНД ШИНЭЭР ХИЙСЭН БОЛОН ЗАСВАР, ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН ПРОГРАММУУД**

№	Программ	
1	Хөдөө аж ахуйн тооллогын программ	Шинэ
2	Мал, махны үйлдвэрлэгчийн үнэ борлуулалтын туршилт судалгаа	Шинэ
3	Судалгааны хяналтын вэбсайт	Шинэ
4	Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны программ	Шинэ
5	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа-2022 программ	Шинэчилсэн
6	Ажиллах хүчний судалгааны программ	Шинэчилсэн
7	Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгааны модуль оруулсан	Шинэчилсэн
8	Дотоод худалдааны сарын мэдээний программ	Шинэчилсэн
9	Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны улирлын мэдээний программ	Шинэчилсэн





## ХОЛБОО БАРИХ

- 14200 Улаанбаатар, Монгол Улс,  
Засгийн Газрын III байр, 306 тоот
- 1900-1212, 261502
- [information@nso.mn](mailto:information@nso.mn)
- [www.nso.mn](http://www.nso.mn) | [www.1212.mn](http://www.1212.mn)
- [/StatisticMGL](#)
- [/StatisticMGL](#)
- [in](#) /StatisticMGL